

2

**Ч.МИЖЭЭХҮҮ**

**ГАДААДЫН ИРГЭДЭД  
ҮЙЛЧЛЭХ "ГЭГЭЭ"  
КОМПАНИЙ (ГАДААДЫН  
МЭРГЭЖИЛТНИЙГ  
ҮЙЛЧЛЭХ ГАЗАР) ҮҮСЭН  
БАЙГУУЛАГДСАН ТҮҮХ**

**Улаанбаатар  
1996 он**

3

## **Гадаадын иргэдэд үйлчлэх "Гэгээ" компаний (гадаадын мэргэжилтэнд үйлчлэх газрын) үүсэн байгуулагдсан түүх**

### **Оршлын оронд**

Монголчууд өнө эртнээс оюун ухаан төгс, эрдэм ном, авьяас билэг бүхий хүнийг харийн өөрийн гэлгүй хүндлэн биширч, эрдэм оюуны нь үр шимийг хртэхийг эрхэм чухалд үзэж ирсэн ард түмэн билээ. Энэ нь ч оюун хөгжил дэвшлийн нэгэн гол хүчин зүйл болгосоор ирсэн хүн төрөлхтний жам ёсноос монголчууд ангид байгаагүйг гэрчлэх ажээ. Жишээ татахад илүүдэх юун.

Их Чингис хаан харь хятан үндэсний Елюй чуцай, Елюй ахай нарыг харийн, хүний гэлгүй дэргэдээ авч дайн байлдаанд ч хамт явж байсан тухай түүх сурвалж бичигт тэмдэглэн үлдээжээ. Чингис хаан, би хамгийг мэднэ, чадна гэж байсангүй, харин ч эрдэмт тэдгээр түшмэдүүдийн оюун билэг, эрдэм чадлыг нь ашиглаж байсан нь энэ биз ээ.

Монголын хожмын их, бага хаадч дэргэдээ улс орноос эрдэм номтой, оюун ухаан, ур авьяастай хүмүүсийг урин ируулж суулган тэдний ур ухаанаар монголчуудын хийж чаддаггүй, мэдэж амжаагүй зүйлсийг тэдний авьяас билэг, ур ухааныг хүндлэн үнэлж байжээ. Жишээ нь: Хувилай хан гэхэд 1272 онд Иранаас үхэр бууны (их бууны) дархан урин ирүүлж их буу хийлгэж байсныг түүхийн сурвалж бичигт тэмдэглэсэн ажээ. Мөн Сүбэдшйн дэргэд Елюй Чуцай байж байлдааны болон бусад зүйлд нь ятган тусалдаг байжээ.

"Дэлхийг байлдан дагуулагчийн түүх" хэмээх алдарт зохиол бичсэн түүхч-эрдэмтэн Жувейни монгол цэргийн нэрт жанжин хан Хулугугийн дэргэд байж дайн байлдаанд нь оролцож явснаас гадна Хулугугийн өршөөлөөр аврагдсан номын санд орж ховор чухаг ном судартай болсноо бахархан өгүүлсэн байдаг. Энэ мэтээр олон жишээг гаргаж болох боловч нуршихыг тэвчин товчлоё.

Хорьдугаар зууны эхэн үеэс монгол оронд дэлхийн олон орноос янз бүрийн замаар, янз бүрийн учир шалтгаанаар элдвийн гадаадын олон тооны жуулчин гийчин, төрөл бүрийн мэргэжилтэй хүмүүс ирж суурьших болсны дотор орос, герман, польш, хятад, япон, англи гэх мэт олон үндэстнүүд байлаа. Тэдний нилээд нь ямар нэг учир шалтгаанаар Монголын тухайн үеийн эрх баригчдаас зөвшөөрөл авсан, урин ирүүлсэн, өнөөгийнхөөр бол мэргэжилтэн, зөвлөх нар байв. Ялангуяа 1911 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний ялалтын үр дүнд бүрэлдэн тогтсон Богд Хаант Монгол Улсын засгийн газраас явуулах болсон тухайн үедээ шинэчлэлийн чанартай бодлогын хүрээнд цэрэг, улс төр, эдийн засаг соёлын салбарт шинэ зүйлүүд хийгдэх болж ирэхэд түүнд монголчуудын маань мэдлэг боловсрол мөхөсдсөний улмаас гадаадаас мэдлэг боловсролтой хүмүүсийг авч ажиллуулах аргагүй шаардлага гарсан ажээ.

1911-1921 оны хооронд цэрэг, санхүү-эдийн засаг, хүн, мал эмнэлэг, гааль худалдаа, жижиг үйлдвэр, аж ахуйн салбарт европ маягийн шинэ зүйлүүд үүсч түүнд орос, герман зэрэг орны мэргэжилтэн хүмүүс ирж монголчуудад туслах, зааж сургах, тэр ч байтугай сургууль, соёлын болон шинжилгээ судалгаа, үйлдвэр аж ахуйн чанартай газруудыг цөөн, бага, жижиг боловч байгуулах болжээ.

Жишээ нь: 1912 онд Хужирбуланд монгол цэргийн сургуулийг европ маягаар байгуулж түүнд орос цэргийн дарга нилээдийг урин ирүүлж багшлуулжээ. 1910-1920 оны Нийслэл Хүрээнд орос сургууль байгуулагдаж, түүнд мэргэжилтэн багш нар ирж орос, монгол хүүхдүүдэд хичээл заах болов. Орос, герман, английн худалдааны пүүс, хоршоо бий болж түүнд монголчуудын хамт тухайн ажлын мэргэжилтэй гадаадын хүмүүс ирж ажиллаж байжээ. Тэдгээр нь үнэн чанартаа гадаадын мэргэжилтнүүд байв.

1921 оны Ардын хувьсгалыг бэлтгэх, ялуулах үйл хэргийн явцад цэрэг улс төр, хувьсгалт тэмцлийн туршлагажсан мэргэжлийн хүмүүсийг монголын хувьсгалчид авч, үйл хэрэгтээ туслуулсан нь мөн л гадаадын мэргэжилтэн ирүүлсэн явдал мөн байв. Тэдний дотор орос, герман, польш, буриад, чех, гүрж, унгар зэрэг үндэстэн, ястнууд орж байсан ажээ.

Ардын хувьсгалын дараагаас тус орны улс төр, цэрэг, эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, сургуулийн зэрэг бараг бүх салбарт гадаадын мэргэжилтэн тэр үеийнхээр "Эрдэмтэн сургагч" нар олноор ирж ажиллах болсон билээ. Тэднийг эхний үед гол төлөв цэрэг, эдийн засаг, сургуулийн хэрэгт олноор урин ируулж ажиллуулсан байна. Аажимдаа гадаадын (зөвлөлтийн) мэргэжилтэн, сургагч, зөвлөх ажиллуулдаггүй газар, байгууллага бараг үгүй болжээ. Энэ нь нилээд хожим болтол үргэлжлэв.

Жишээ нь: 1940-өөд оны сүүл үеийн нэгэн баримтаас үзэхэд манай бүх яам, тусгай газар, олон нийтийн төв байгууллага, томоохон үйлдвэр аж ахуйн газрууд зөвхөн зөвлөх, сургагч гэхэд 1-2-ыг урин ирүүлж ажиллуулж байжээ. Энэ нь хэд хэдэн учир шалтгаантай байсан бололтой.

Нэгдүгээрт, ардын хувьсгал ялмац тус орны нийгэм-улс төр, эдийн засан, цэргийн бүх үйл ажиллагааг урьд өмнө нь Монгол оронд байгаагүй цоо шинэ арга, ухаанаар хөтлөн явуулах тулгамдсан зорилт тулгарав. Мөн нам, эвлэл, үйлдвэрчин, эмэгтэйчүүдийн болон засаг төрийн цоо шинэ байгууллагууд байгуулагдаж, монголын шинэ нийгмийн төр, оюун санааны бүх салбарыг өмнөхөөс өөрөөр удирдан жолоодох шаардлага тавигдав. Гэтэл энэ бүх зорилт, тулгамдсан шаардлагыг хэрэгжүүлэгч мэдлэг боловсролтой хүн монгол оронд үнэн хэрэгтээ хуруу дарам цөөн байжээ.

Хоёрдугаарт: Мэдлэг мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэж, тэднийг өсч өндийх мэдлэг мэргэжлийг нь жинхэнэ ажил амьдралд хэрэглэж үр шимийг нь үзэхэд багагүй цаг хугацаа шаардагдах байсан нь тодорхой.

Гуравдугаарт: Хагас колончлолын байдалд оршиж бас дайн, самууны хөлд нухлагдсан, уулаас ядуу буурай байсан монгол орон бүхий л салбартаа хэрэгцээтэй боловсон хүчнээ өөрийн хүн, хүч хөрөнгөөр бэлтгэж хангах эдийн засаг, оюуны бааз суурь, хүчин чадавхиар мөхөсдөж байжээ.

Эдгээр болон Монгол орон өөдлрх, өсч хөгжих шаардлагатай холбоо бүхий бусад олон учир шалтгаан нь гадаадын юуны өмнө тухайн үедээ түшиж тулах, харилцах ганц орон болсон Зөвлөлт Орос Улсаас янз бүрийн мэргэжилтнэ (сургагч) нарыг урин авч ажиллуулахад хүргэжээ.

Цаашдаа тэднийг олноор урин ирүүлж ажиллуулах болжээ. Энэ нь монгол улс өөрийн үндэсний мэргэжилтнээ хэр чадлаараа бэлтгэж байсан хэдий ч хөгжлийн шаардлагыг хангахгүй байсантай шууд холбоотой байв.

1921-1950-иад оны дунд үеийг хүртэл Монголд ажиллах гадаадын мэргэжилтний утхай асуудал нь зөвлөлтийн мэргэжилтний тухай л асуудал байв. Тэднийг урьж ирүүлэх, үйлчилгээ, хангамжийн тухай асуудал нь ялангуяа монгол, зөвлөлтийн улс төр, эдийн засаг, соёл шинжлэх ухаан, боловсрол, эрүүлийг хамгаалахын салбарын харилцааны дотор ихээхэн анхаарал тавьдаг асуудлын нэгэн байжээ.

1950-иад оны дунд үеэс Монгол улс социалист гэгдэж байсан улс орнуудтай улс төр, эдийн засаг, соёлын өргөн харилцаа тогтоож ажиллах болсонтой холбоотойгоор эдгээр орнуудаас мэргэжилтэн урин ажиллуулж эхлэв.

1955 онд Монгол, Хятадын засгийн газруудын хооронд байгуулсан хэлэлцээрийн дагуу Хятадын мэргэжилтэн (кадр), мэргэжилтэй ажилчид олон мянган хүн Монголд ирж ажиллах болов.

Чухамхүү энэ үеэс гадаадын мэргэжилтний асуудал урьдын адил дан ганц зөвлөлтийн мэргэжилтний тухай асуудал байхаа больжээ.

Монголд гадаадын мэргэжилтнийг урих, тэднийг үйлчлэх үйлчилгээний зарчмын асуудлыг улс хоорондын гэрээ, хэлэлцээрээр дээд хэмжээнд тогтоож, мэргэжилтэн ирсэн тухайд нь үйлчилгээг Монгол улс өөрийн байгууллагуудаар хангуулж иржээ.

1957 оныг хүртэл гадаадын мэргэжилтнийг үйлчлэх үйлчилгээг үндсэндээ мэргэжилтэн урьсан Монголын тэр байгууллага хариуцан гүйцэтгэж байлаа.

1950-иад оны дунд үеэс олон улс орноос янз бүрийн нөхцөл, болзолтойгор ажиллах олон тооны мэргэжилтэн ирэх болсон нь тэдний үйлчилгээ, хангамжийг дагнан эрхлэх байгууллагыг бий болгохыг зүйл ёсоор шаардах болжээ.

Энэхүү товч түүхэн тоймд тэрхүү байгууллага үүсэн байгуулагдсан хийгээд түүний цаашдын өсөлт хөгжил, өөрчлөлт шинэчлэлт, хувьсал, үндсэн үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, тэнд ажиллагсдын талаар товч өгүүлэхийг оролдов.

Энэхүү тоймыг бичүүлэх болсон нь нэгдүгээрт, 1997 онд өнөөгийн "Гэгээ" компаний эх үүсэл болох "мэргэжилтэн нарын ахуй хангамжийг эрхэлсэх групп" байгуулагдсаны 40 жилийн ой тохиох, хоёрдугаарт, 40 жилийн туулж ирсэн түүхэн замналаа эргэн нэг харж, өнөө ирээдүйгээ цэгнэн нэг бодох гэсэн тус компаний эрхэм нөхдийн хүсэл, зорилготой шууд холбоотой болохыг өгүүлье.

Зохиогчийн мэдлэг чадвар мөхөс, осол омдгой зэргээс үүдэн алдаа мадаг, буруу ташаа зүйл бичигдсэн байх аваас засч зарлуулан хэлж туслахыг эрдэмт мэргэн дүү нараасаа хатамжлан хүснэм.

### **Зохиогч**

*Товч түүх*

*Товч:* **Гадаадын иргэдэд үйлчлэх "Гэгээ" компаний үүсэл**

✓ Бүгд Найрамдах Монгол Ард Улс (тэр үеийн нэрээр)-ын гадаад улс төр, эдийн засгийн харилцаа 1950-иад оны эхэн үеэс ихээхэн өргөжиж иржээ. Энэ нь дэлхийн 2-р дайны дараа үүсэн байгуулагдсан социалист гэгдэж байсан улс орнуудын эдийн засгийн өргөн харилцаа тогтоож эхэлсэнтэй шууд холбоотой байв. Мөн ЗХУ-тай тогтоосон эдийн засгийн харилцаагаа ч өргөтгөсөн нь үүнд нөлөөлөв. Үүний дүнд эдгээр орнуудын тусламж, оролцоотойгоор байгуулж байсан тэдгээр үйлдвэр, аж ахуйн газар, салбарт ажиллах, өндөр мэдлэг боловсрол, мэргэжилтэй үндэсний боловсон хүчин Монгол улсад бас л бүрэн бэлтгэгдээгүй байсан нь эдийн засгийн харилцаа тогтоосон нилээд улс орнуудаас мэргэжилтэн урин ажиллуулахад хүргэв. Гаднаас урьж ирүүлсэн мэргэжилтний тоо жилээс жилд өсч ирснээр тэдэнд Монголын талаас үзүүлэх үйлчилгээ хангамжийн хэмжээ, чанар, үйлчилгээний ажлын зохион байгууллалтыг үндсээр нь өөрчлөн сайжруулах шаардлага гарав.

6

✓ Бүр 1930,40-өөд оноос эхлэн 1967 оныг хүртэл Сайд нарын Зөвлөл, Намын Төв Хорооноос гадаадын (зөвлөлтийн) мэргэжилтэн, сургагч нарын үйлчилгээ, хангамжийн талаар ихээхэн анхаарч цөөнгүй тооны тогтоол, шийдвэр гаргаж байв. Энэ үеэс дээд байгууллагаас зарчмын тогтоол, шийдвэрийг гаргадаг, түүнийг мэргэжилтэн урьсан байгууллага өөрийн хүч, хөрөнгөөр шууд хариуцан хэрэгжүүлэг систем тогтсон ажээ. Аль эртнээс мэргэжилтэн нарт орон сууц, гэрэл, дулаан, түлээ түлш, ус, унаа хөсгийг үнэ төлбөргүй хэрэглүүлэх журам тогтсон байв. Үүнээс гадна үндэсний мэргэжилтэн, ажилтнаас дээгүүр цалин хөлс, төрөл бүрийн нэмэгдэл цалин ч олгодог журамтай байжээ. Мэргэжилтнүүдэд зориулсан дэлгүүр, гуанз, эмнэлэг, амралт, сувилалын газар, сургууль, угаалга, цэвэрлэгээний болон гутал хувцас оёх, засах газар хүртэл байгуулж ажиллуулжээ.

✓ Манай оронд нийтийн орон сууцны асуудал бараг тавигдаагүй байхад гадаадын мэргэжилтний орон сууцны сан (фонд) байгуулах шийдвэр гарчээ. Төв орон нутагт мэргэжилтний үйлчилгээ, хангамжинд зориулсан үйлдвэрийн болон хүнсний барааны нөөц сан байгуулж, түүнд байх барааны тоо хэмжээ, нэр төрөл, олгох норм хэмжээ, хэрхэн хангаж байх журмыг хүртэл тогтоожээ.

✓ 1940-өөд оны дунд үеэр зөвлөлтийн мэргэжилтний хангамж, үйлчилгээний байдлыг шалган хянаж байх үүргийг Гадаад явдлын яаманд хариуцуулж, мэргэжилтнийг бүртгэх, хангамж, үйлчилгээг нь шалган хянаж байх үүрэг бүхий байцаагч нэгийг мөн яаманд бий болгожээ. Мөн Сэлэнгэ аймгийн төв Сүхбаатар хотод мэргэжилтнийг улсын хилээр орж ирахэд нь угтан авч нааш явуулах, буцаж байгааг нь үдэн гаргаж өгөх үүрэг бүхий төлөөлөгч нэг хүнийг Гадаад явдлын яамны харьяанд суулгажээ.

✓ 1950-иад оны эхэн үеэс гадаадын мэргэжилтнийг ажиллуулахад тэднийг тохилог орон сууцаар хангах асуудал хамгийн хурц асуудал болжээ. Шинээр орон сууц барих, хуучныг засч тохижуулах зэрэг арга хэмжээ авч байсан хэдий боловч орон сууц туйлын хүрэлцээгүй байв. 1954 онд Сайд нарын Зөвлөлийн нэгэн тогтоолоор уригдаж ирсэн Зөвлөлтийн мэргэжилтнийг орон сууцаар хангаж байх явдлыг цаашид Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргаанд хариуцуулж, зөвлөлтийн мэргэжилтний орон сууцны фондыг эрхэлсэн байцаагч нэгийг мөн хотын гүйцэтгэх захиргааны орон тоонд бий болгожээ.

✓ Эдгээрээс өөр гадаадын мэргэжилтний үйлчилгээ, хангамжийг дагнан хариуцсан байгууллага, хүн 1957 оныг хүртэл байсангүй ажээ. Эдгээр байгууллага хүмүүс хэдий хүртэл, хэрхэн ажилласан тухай мэдээ баримт байхгүйгээс гадна тэдгээр нь гадаадын мэргэжилтний үйлчилгээ, хангамжийг бүхэлд нь хариуцаж байгаагүй нь тодорхой байна. Ингэхээр 1957 оны дунд үеийг хүртэл гадаадын мэргэжилтнийг үйлчлэх биеэ даасан газар байгууллага байгаагүй явж иржээ.

✓ Сайд нарын Зөвлөлийн 1957 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 307 дугаар тогтоолоор Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх техникийн тусламжийн газрыг татан буулгаж, түүний оронд техникийн тусламж, мэргэжилтний асуудлыг эрхэлсэн Засгийн газрын төлөөлөгчийг 4 хүний орон тоотойгоор бий болгож, төлөөлөгчөөр Зундуйг томилжээ. Засгийн газрын энэхүү төлөөлөгч нь өөрийн эрхэлсэн нэгэн үүрэг болох мэргэжилтний асуудлаар санал дүгнэлт боловсруулан Сайд нарын Зөвлөлд оруулах, гарсан тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг Засгийн газрын түвшинд зохион байгуулах гол үүрэгтэй байсан.

✓ Засгийн газрын төлөөлөгч томилогдсоны дараа 1957 оны 8 дугаар сарын 2-ны өдөр Сайд нарын Зөвлөл Намын Төв Хорооноос "Мэргэжилтэн нарын үйлчилгээг сайжруулах арга хэмжээний тухай" 342/261 дүгээр

7  
39

тогтоол гаргажээ. Энэхүү тогтоолд: "...манай улсад уригдан ирж ажиллаж байгаа мэргэжилтэн нарт тавтай, тохитой бөгөөд хамгийн үр бүтээлтэй ажиллах бүх талын нөхцлийг ханган өгч, тэдгээрээс сурах явдал нь мэргэжилтэн нарыг урьж ажиллуулж байгаа яам, гзэрууд болон бусад бүх байгууллагын эрх баригчдын анхаарлын төвд үргэлж байвал зохих асуудал мөн " 1 гэж уул асуудлын ач холбогдол, мөн чанарыг анхааруулан тэмдэглэжээ.

✓ Энэхүү тогтоолоор уригдан ирж ажиллаж байгаа гадаадын мэргэжилтний талаар гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж, ямар арга хэмжээ авч байгаа зэргийг тогтмол авч хэлэлцэж байхыг мэргэжилтэн бүхий бүх яам, албан газар, аймаг хотын гүйцэтгэх захиргаа, намын хороодод; авьяас, сонирхолтой монгол хүмүүсийг гадаадын мэргэжилтэн нэг бүрийг заавал дагалдуулан сургахыг албан, үйлдвэрийн газруудад тус тус даалгав. Гадаадын мэргэжилтний орон сууц, үйлчилгээний барилгуудыг улсын банкны зүүн ба өмнө хэсэгт төвлөрүүлэн байрлуулах, гэдэнд зориулж орон сууц хуваарьлах, хуучин сууцыг засварлах, мэргэжилтэнд хуваарилсан орон сууцыг дотоод тоног төхөөрөмж, эд хогшлын хамт цаашид гагцхүү мэргэжилтэнд зориулан ашиглах, тэдний байр сууцны дотоод төхөөрөмжид зориулан 100 айлын мебель захиалан хийлгэх зэрэг арга хэмжээ авахаар холбогдох яам, газруудад даалгажээ.

✓ Гадаадаас уригдаж ирсэн мэргэжилтний зардлыг төлөвлөх болон санхүүжүүлэх журмыг анх удаа энэхүү тогтоолоор 3 үндсэн хэлбэрээр журамлан тогтоосон байна. Үүнд: а/техникийн тусламжийн шугамаар хийгдэж байгаа барилга байгууламжийн болон хайгуул шинжилгээний ажлын шугамаар ирсэн мэргэжилтнүүдийн бүх зардал (буцахын зам хоног, цалин хөлс, орон сууц, гэрэл, түлш, мөн удаан хугацаагаар ирж, тусгай орон сууц хэрэглэх хүний орон сууцны дотоод төхөөрөмж, эд хогшил бэлтгэх зардал)-ыг хөрөнгө оруулалтаар; б/үйлдвэр, аж ахуйн газар, байнга ажиллахаар ирсэн мэргэжилтний бүх зардлыг уг газруудын үйл ажиллагааны зардлын төсвөөр; в/төсөвт газруудад ажиллуулах мэргэжилтнүүдийн бүх зардлыг уг албан газрын төсвөөр тус тус санхүүжүүлж байхаар тогтоожээ.

✓ Энэхүү тогтоолын 3 дугаар зүйлийн "ё"-д мэргэжилтэн нарын ахуй хангамжийг эрхэлсэн группийг 3 хүний орон тоотойгоор энэ оны 8 дугаар сарын 15-наас эхлэн хот, нийгмийн хангамжийн газарт бий болгохыг Хотын гүйцэтгэх захиргаа (Батжаргал)-д зөвшөөрсүгэй. 1 гэж заажээ. Үүгээр **гадаадын мэргэжилтнийг үйлчлэх байгууллагын** эх үндэс Монгол оронд анх тавигджээ. Энэ тогтоолд доорхи гурван үндсэн зүйл тусгагдсан байна.

✓ **Нэгд:** Шинээр бий болгож байгаа группийн эрхлэх үүрэг зорилтыг "мэргэжилтэн нарын ахуй хангамжийг эрхэлсэн..." байхаар заажээ. Ийнхүү эрхлэн хийх болсон ажил, үүрэгтэй нь уялдуулан авч үзвэл энэхүү групп нь анх тодорхой байгууллага-нэгжийн байдлаар үүсэн бий болжээ.

✓ **Хоёрт:** Группийг 3 хүний орон тоотойгоор бий болгохоор заажээ. Энд цөөн ч гэсэн орон тоотой, " групп" хэсэг гэсэн албан ёсны нэртэй нэгэн байгууллага, өөрөөр хэлбэл ажил, үүргийн тодорхой зорилттой, орон тоотой, албан ёсны нэртэй нэгэн байгууллага нэгж үүссэн нь маргаангүй байна.

✓ **Гуравт,** Тус группийг Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны харьяа хот нийгэм, хангамжийн газарт байгуулсан нь эрхлэн явуулах ажлын чиглэл нэг байсантай холбоотой байв. Тэгэхээр сар хүрэхгүй хугацааны өмнө бий болгосон техникийн тусламж, мэргэжилтний асуудал эрхэлсэн Засгийн газрын төлөөлөгч нь энэхүү группийн дээд шатны байгууллага

8

болжээ. Харин хотын гүйцэтгэх захиргаа, хот, нийгэм хангамжийн газар нь шууд ахрыяалагдан ажиллах газар нь байв. Ийнхүү гадаадын мэргэжилтний үйлчилгээ, хангамжийг эрхлэж явуулах байгуулагуудын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо бүрэлдэн тогтож эхэлжээ.

Энэхүү тогтоолын хавсралт-"мэргэжилтэн нарт зориулах байрны тодорхойлолт"- оор 12 байшингийн 100 айлын сууцыг мэргэжилтнүүдэд олгохоор хуваариласнаас гадна Цэрэг ба Нийгмийг аюулаас хамгаалах яам, Геологи шинжилгээний газар, өнгөт металл, нефтийн үйлдвэрүүдийг удирдах газруудын нэр дээр уригдан ирсэн мэргэжилтний орон сууцыг тэдгээр газрууд хариуцан хангахаар тогтжээ.

Энэ тогтоолыг хэрэгжүүлэх үндсэн дээр Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргаанаас 1957 рэы 10,12 дугаар саруудад хоёр ч тогтоол гаргаж, 100 айлын орон сууцанд тавих, 55 мянган төгрөгийн үнэ бүхий мебель тавилгыг мэргэжилтний үйлчлэх группийн мэдэлд шилжүүлэх, мэргэжилтэн суух 40 айлын сууцанд засвар хийх зэрэг арга хэмжээ авчээ.<sup>1</sup> Үүнээс үзсэн ч мэргэжилтний хангамжийг эрхлэх групп нь өөртөө эд зүйл авч хариуцан зарцуулах, зохион байгуулах эрх мэдэл бүхий газар (байгууллага), өөрөөр хэлбэл хуулийн этгээд байсан нь тодорхой байна.

1.УБХУА,с.1,д.7,хн.1562,х.364-365

Хоёр. **Гадаадын мэргэжилтнийг үйлчлэх байгууллагын цаашдын хөгжил, үйл ажиллагаа**

✓ 1958 оны 4 дүгээр сард Монгол, Зөвлөлтийн засгийн газруудын хооронд мэргэжилтнийг урин ажиллуулах асуудлаар шинээр хэлэлцээр байгуулагдав. Европын социалист гэгдэж байсан хэд хэдэн орноос мэргэжилтэн урин ажиллуулах гэрээ хэлэлцээрийг 1958 онд байгуулжээ. Эдгээр гэрээ, хэлэлцээрээр монгол улс гадаадын мэргэжилтний үйлчилгээ, хангамжийг урьдахаас нэлээд нарийн, өргөн хэмжээнд хариуцан гүйцэтгэх болов. Ирэх мэргэжилтнийн тоо ч өссөөр байв. Үүнтэй уялдаатайгаар мэргэжилтний хангамж эрхэлсэн группыг өөрчлөн байгуулах шаардлага ч гарчээ. Энэ байдлыг харгалзан Сайд нарын Зөвлөлийн 1958 оны 8 дугаар сарын 22-ны "Мэргэжилтний зарим хангамжийн тухай" 274-р тогтоолоор: "...Улаанбаатар хотод байнга ажиллах мэргэжилтнийг ... дотоод эд хогшлоор бүрэн төхөөрөмжлөгдсөн орон сууцаар хангаж байх..."<sup>1</sup> -ыг 1958 оны 9 дүгээр сарын 1-нээс эхлэн Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргаанд хариуцуулж, "Үүнтэй холбогдуулан тэдгээр мэргэжилтнийг үйлчлэх товчоог аж ахуйн тооцооны үндсэн дээр 1958 оны 9 дүгээр сарын 1-ний дотор байгуулан ажиллуулахыг Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргаа (н.БАТЖАРГАЛ)-д зөвшөөрсүгэй"<sup>2</sup> гэснээр групп нь **Товчоо** болон өргөжин байгуулагдав. Энэ тогтоолоор 300 шахам орон сууцыг гадаадын мэргэжилтний орон сууцанд зориулан хуваарилсан байна.

✓ Үйлчлэх товчооны дарга байсан Ононхүүгээс 1959 оны эцсээр гаргасан нэгэн илтгэх хуудсанд дурьдсанаас үзвэл тус товчоонд дарга, нягтлан бодох, мөнгөний нярав-бичээч, жолооч тус бүр 1, аж ахуйн комендант-байрын төлөөлөгч 5, буудлын дежур 3 зэрэг нийт 15 хүн ажиллаж байжээ. Энэ илтгэх хуудсанд орон тоог 24 болгох, авто машин нэгийг олгох, гадаадын мэргэжилтэнд зориулан хуваарилсан байрнаас монгол айлуудыг гаргах, шинээр орон сууц олгох зэрэг санал тавьжээ. Энд дурдсанаас үзвэл гадаадын мэргэжилтэнд зориулан 350 гаруй орон сууц

9

хуваарилагдсанаас 250 гаруйхныг уул товчооны мэдэлд байгааг дурьджээ. Мөн 120 гаруй мэргэжилтэн байргүй байгаа, үйлчлэх товчоо үйлчлэх үүргээ гүйцэт биелүүлж чадахгүй байгаа зэргийг дурьдсан байна.

✓ Мэргэжилтнийг үйлчлэх товчоо нь 1958 оны 9-р сараас 1960 оны 7 дугаар сар хүртэл Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны дэргэд ажиллажээ.

✓ Сайд нарын зөвлөлийн 1960 оны 7-р сарын 2-ны өдрийн "Гадаадын мэргэжилтнийг үйлчлэх товчооны тухай" 296 дугаар тогтоолоор : "Гадаад орнуудаас уригдаж ирсэн мэргэжилтэн нарыг үйлчлэх ажиллагааг сайжруулах зорилгоор Улаанбаатар хотын хөдөлмөрчдийн депутатуудын хурлын гүйцэтгэх захиргааны дэргэдэх Гадаадын мэргэжилтийг үйлчлэх товчоог 1960 оны 7 дугаар сарын 1-нээр тасалбар болгон Гадаад орнуудтай эдийн засгийн талаар харилцах улсын хорооны (ГӨЭЗТХУХ) харьяанд шилжүүлэн өгч, аж ахуйн тооцоогоор ажиллуулсугай" <sup>1</sup> гэснээр Товчоо Засгийн газрын харьяа байгууллага болов.

Товчоо Сайд нарын Зөвлөлийн Улсын хороонд шилжсэн нь нэгд, гадаадын мэргэжилтнийг урих, ажиллуулах, төлбөр тооцоог нь хийх зэрэг мэргэжилтэнтэй холбогдох бүхий л асуудлыг дээрхи хороо эрхэлж байсантай, хоёрт, мэргэжилтний үйлчилгээ, хангамжийг ихээхэн анхааран үзэх болсонтой холбоотой байв. Товчооны үйл ажиллагааг сайжруулах, материал техник, хүн хүч, төсөв хөрөнгөөр хангах талаар дараалсан арга хэмжээ авч эхлэв.

ГӨЭЗТХУХ-ын даргын тушаалаар 1960 оны 9 дүгээр сард Үйлчлэх товчооны орон тоог 58 хүнээр, цалингийн сарын фондыг 20000 орчмоор баталсан нь орон тоо 1959 оны эцэст байснаас бараг дөрөв дахин нэмэгджээ. Энэ үед үйлчлэх товчоо захиргаа, зочид буудал, гуанз гэсэн гурван хэсгээс бүрдэж аж ахуйн тооцоон дээр ажиллаж байв.

✓ Үндсэн үйл ажиллагаа нь гадаадын мэргэжилтнүүдэд орон сууц олгож түүнд нь дотоод тоног төхөөрөмж тавьж өгөх, байранд нь жижиг засвар үйлчилгээ, цэвэрлэгээ хийх, мэргэжилтнийг ойр зуурын унаа хөсгөөр хангах, зочид буудалдаа байрлуулах, гуанз худалдаагаар үйлчлэхэд оршиж байв. Энэ үед тус үйлчлэх товчооны мэдэлд 10 гаруй байшинд мэргэжилтэн байрлуулж үйлчилдэг байжээ. Мэргэжилтний нэг байранд 30 орчим эд хогшлын зүйл тавьж өгдөг байв.

Сайд нарыг Зөвлөл 1961 оны 5 дугаар сарын 17-нд "Гадаадын мэргэжилтнийг үйлчлэх товчооны талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоол гаргав.

Уул тогтоолоор гадаадын мэргэжилтэнд үйлчлэх зорилгоор яам, албан газарт автомашин олгодог явдлыг зогсож, тэдгээр олгосон машинаас 8-ыг Улсын барилга, эдийн засгийн Комисст (энэ үед Гадаадтай эдийн засгийн талар харилцах улсын хороо өөрчлөн байгуулагдаж, Улсын барилга, эдийн засгийн Комисс болсон байжээ.-Ч.М) шилжүүлжээ. Гадаадын мэргэжилтний орон сууц, уналгын хөлс, түлш, цэвэр ба бохир усны зардал, байрын дотоод төхөөрөмжийн элэгдэл, хорогдлын зардал зэргийг яам, тусгай гарзрууд Үйлчлэх товчооны нэхэмжлэлээр саадгүй шилжүүлж байхаар тогтоов. Мөн гадаадын мэргэжилтний орон сууцны дотоод төхөөрөмж, эд хогшил, хүнсний зүйлийг Улсын барилга, эдийн засгийн Комиссын захиалгаар тасралтгүй хангаж байхыг заагаад тэдний сууж байгаа байрны орчныг тохижуулах, авто машины гарааш, агуулах барих, мэргэжилтнүүдийг урамшуулах зэрэгт зориулах 130 мянган төгрөгийг үйлчлэх товчоонд олгов. ҮЭТЗ-ийн харьяа цагаан хоолны гуанзыг мэргэжилтний гуанз болгожээ.



✓ Сайд нарын Зөвлөл дээрх тогтол гаргаснаас хойш удалгүй 1961 оны 6 дугаар сарын 7-нд "Социалист орнуудаас уригдаж ирсэн мэргэжилтний үйлчилгээг сайжруулах арга хэмжээний тухай" томоохон тогтоол гаргажээ:

Энэхүү тогтоолд "1.Улсын барилга, эдийн засгийн комиссын харьяа Гадаадын мэргэжилтнийг үйлчлэх товчоог өргөтгөн, төлөвлөгөө- санхүүгийн хэлтэс үйлчилгээ, ахуй хангамжийн хэлтэстэй, улсын төсвөөр санхүүждэг газар болгон байгуулж, түүний харьяанд аж ахуйн тооцоотойгоор ажиллах мэргэжилтний гуанз, автобааз, мөн дэргэдээ барилга засварын групп, угаалгын газартай орон сууцны захиргаа байгуулахыг Улсын барилга эдийн засгийн комисс (н.МАЙДАР)-т зөвшөөрсүгэй." гэж зааснаар дөрвөн жил орчмын өмнө анх 3 хүний орон тоотой бий болж байсан "мэргэжилтэн нарын ахуй хангамжийг эрхэлсэн групп" нь үйлчилгээ, хангамжийн томоохон газар болж өргөжин байгуулагдав.

Энэ тогтоолоор мэргэжилтнийг үйлчлэх байгууллагын үйл ажиллагаанд эргэлтйн үе эхлэв. Энэхүү тогтоолд олон чухал заалт орсны дотор: шинээр байгуулагдсан Гадаадын мэргэжилтнийг үйлчлэх газрын (ГМУГ) харьяа аж ахуйн тооцоотой ажиллах газруудад шаардагдах эргэлтйн хөрөнгийг гаргах, мэргэжилтэнд автомашин олгох журам, түүний үнэ хөлсийг төлөх тарифийг тогтоох талаар тодорхой зааж өгөв.

Энэ тогтоолоор мэргэжилтэнд олгосон сууцны үнийг нийтийнхээс 10 хувиар илүү байх, мэргэжилтэнд орон сууц олгохдоо өөрийн улсад нэг хүнд ногдуулан бодож олгодог талбайн хэмжээг баримтлахаар тогтоожээ. Мөн нийтийн үйлчилгээний орон сууцанд суух гадаадын мэргэжилтний нэг гэр бүлд хэрэглүүлэхээр олох эд хогшлын тоо хэмжээг тогтоожээ.

Газрын албан ёсны нэрийг "Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн Барилга, эдийн засгийн комиссын Гадаадын мэргэжилтнийг үйлчлэх газар" гэх болов.

Тогтоол гармагц түүнийг хэрэгжүүлэх талаар нэлээд ажил зохиосон байна. Комиссын даргын тушаалаар Газрын даргаар Зулыг томилжээ. 1961 оны 7 дугаар сард тус газрын даргын тушаалаар газрын авто баазыг байгуулж, дүрмийг нь батлав.

*Уг мэдээг олж авч...* → "Алтай" зочид буудлыг рестораны хамт газарт шилжүүлэн авч, 136 хүнийг ажилд шинэчлэн томилжээ. Газрын сүүлийн хагас жилийн санхүү-эдийн засгийн төлөвлөгөөг шинээр хийж батлав. (Энэ далимд өгүүлэхэд энэ үеэр Комиссын даргаас гаргасан нэгэн тушаалд гадаадын мэргэжилтэнд үйлчлэх товчоо байгуулагдсан цагаасаа хойш тайлан баланс гаргаагүй байсыг дурьдсан бий.) Энэхүү төлөвлөгөөгөөр бол 1961 оны сүүлийн хагас жилд тус газрын орон сууцны захиргаа 1019.5, автобааз 819.2, Алтай зочид буудал 642.3 мянган төгрөгийн орлого тус тус оруулж, 1404.8, 870.7, 574.5 мянган төгрөгийн зардлыг тус тус гаргахаар байв.

Энэ үед орон сууцны захиргаа нэлээд алдагдалтай ажилладаг, түүнийг нь бусад хэсгийн орлого, мөн улсаас нөхөж байсан ажээ. Газрын хэмжээнд хамгийн олон хүн ажилладаг газар нь зочид буудал, гуанз болов.

1961 онд орон сууцны 10 гаруй байшинтай байсны дээр мөн оны эцсээр 4-5 байр байшин шинээр хүлээн авч гадаадын мэргэжилтнүүдийг оруулжээ. Мэргэжилтэнд байр хуваарилуулан авах, тэдгээрийг төхөөрөмжлөхөд тус газар нэлээд өргөн эрх мэдэлтэй болжээ. 1961 оны эцсээр тус газрын хэмжээгээр 170-аад хүн ажиллах болов. Энэ нь шинээр 40 гэрүй автомашин бүхий авто бааз байгуулагдсан, орон сууцны хэд хэдэн байшин хүлээн авсан зэрэгтэй холбоотой байв.

1962 оны 3 дугаар сард тус газрын 1961 оны үйлвэр-санхүүгийн үйл ажиллагааны дүн-тайлан балансыг гаргажээ. Энэ нь архиваас одоогоор олдож буй тус газрын анхны тайлан баланс юм. Түүнд тэмдэглэгдсэнээс

115  
үзвэл 1962 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар ГМҮГ нь 1961 оны 1 дүгээр сарын 1 гэхэд 33248219 төгрөг 17 мөнгөний үндсэн хөрөнгөтэй байсан бол 1962 оны 12 дүгээр сарын 1-ний байдлаар 34945271 төгрөг 06 мөнгөний үндсэн хөрөнгөтэй болжээ.<sup>1</sup> Үндсэн хөрөнгийн 90 гаруй хувийг орон сууцны байшингууд эзлэж байв. 1961 онд үйл ажиллагаагаа явуулахын тулд тус газар 1 сая 366 мянга 750 төгрөгийн зардал гаргасныг тайлан балансдаа дурьджээ.

Газрын харьяа нэгж хэсгүүдийн хувьд гэвэл "Алтай" зочид буудал 2512.9 мянган төгрөгийн үйлдвэрлэл, үйлчилгээний ажил гүйцэтгэж төлөвлөгөөгөө 199.5 хувиар, авто бааз 664.8 мянган төгрөгийн үйлчилгээ хийж 107.4 хувиар, орон сууцны захиргаа 4399.6 мянган төгрөгийн үйлдвэрлэл, үйлчилгээний ажил гүйцэтгэж төлөвлөгөөгөө 151.8 хувиар биелүүлснийг тайлан балансдаа дурьджээ.

Газрын хэмжээгээр орлогын төлөвлөгөөг 51.8 хувиар давуулжээ. Энэ нь тус газрын анхны үеийн үйл ажиллагааны үр дүн түргэн өсч байсныг гэрчлэх ажээ.

Гадаадын янз бүрийн орноос мэргэжилтэн олноор ирэх болж, тэдэнд гуанз, зочид буудлаар үйлчлэх болсонтой уялдан, үйлчилгээнд соёлч байдал нэвтрүүлэх, ялангуяа хоол ундны чанар, ариун цэвэр, өнгө үзэмж, хүмүүсийн үйлчилгээний соёлыг эрс сайжруулах, нэр төрлийг олшруулахад ихээхэн анхаарч эхлэв. Энэ үед ЗХУ, БНУАУ, Болгар зэрэг оронд хүмүүсээ явуулж сургах, хятад тогооч нарыг авч ажиллуулах гэх мэт ажил зохиж байжээ. Ажиллагсадынхаа амьдрал ахуй, ажиллах нөхцлийг эхнээс нь нэлээд анхаарч цалин хэрэглэлийг нэмэгдүүлэх, орон байраар хангах арга хэмжээг авч эхэлжээ. Эдгээр нь байгууллагын цаашдын өсөлт, бэхжилт ажлын үр дүнд нөлөөлж байв.

Энэ үед мэргэжилтнийг үйлчлэх ажлыг сайжруулах тухай газрын даргын тушаал, шийдвэр, заавар, журам нэлээд гарч хэрэгжиж байжээ. 1962 оны эхэн үед тус газарт 22 байшин гадаадын мэргэжилтэнд зориулагдан шилжин ирээд байсны 17 нь шууд хариуцан эзэмших, 5 нь шууд биш журмар хариуцах байшин байжээ. Эдгээр байшингуудад нийтдээ 724 айл сууж үйлчлүүлж байжээ.<sup>1</sup> Мэргэжилтний болон тэдний гэр бүлд зориулж янз бүрийн ор 2000, бичгийн болон бусад ширээ 1900, төрөл бүрийн шүүгээ 1050-аадыг орон сууцанд нь тавьж өгч байжээ. Мөн орны даавуу 3346, хөнжлийн даавуу 3094-ийг бэлтгэн өгсөн байна. 1962 онд газрын авто бааз 45 автомашинтай болсны 20 нь суудлын машин байв.

Аймаг хотуудад гадаадын мэргэжилтнийг үйлчлэх товчоо байгуулах, тэдний ахуй хангамжийг сайжруулах талаар Сайд нарын Зөвлөлөөс хэд хэдэн тогтоол гаргажээ. Тэдгээрийн нэгэн болох Сайд нарын Зөвлөлийн 1962 оны 277 дугаар тогтоолоор ГМҮГ-ыг татан буулгаж Сайд нарын Зөвлөлийн Барилга, эдийн засгийн Комисст нэгтгэж, тус Комисст үйлчилгээ, санхүү, аж ахуйн асуудал эрхэлсэн аппарат байгуулав. Урьд нь ГМҮГ-ын дарга байсан Зул Комиссын орлогч дарга бөгөөд аппаратын дарга болсон байна.

ГМҮГ татан буугдсанаар орон тоо нь нэлээд цөөрчээ. Газрын харьяанд байсан буудал, авто бааз, орон сууцны захиргаа урьдын адил үйл ажиллагаагаа явуулж байв. Үүнээс үзвэл тус газрын захиргааг л татан буулгаж, Комисст нь нэгтгэсэн гэж үзэх үндэстэй байна.

Уул газар татан буугдсанаар гадаадын мэргэжилтний үйлчилгээ, хангамжийн ажил багассангүй, харин ч нэмэгдсээр байв. 1962 онд тус газрын нийт орон тоог 260 гаруй хүнээр баталж өгснийг дээрх тогтоол гарсны дараа нэлээд цөөрүүлсэн ажээ. Газрын 1962 оны ажил үйлчилгээ хэвийн явж, төлөвлөгөөт зорилтоо биелүүлж, орлого, зардал, нь бараг

12

тэнцэж ирсэн байна. Тэр үеийн зарим баримтанд дурьдсанаас үзвэл энэ үед Улаанбатарт гадаадын мэргэжилтэн 806 хүн, гэр бүлийн 1128 хүний хамт байж тус газраар үйлчлүүлсэн байна. Жилдээ тус газар 4 сая шахам төгрөгийн үйлдвэр-үйлчилгээний ажил гүйцэтгэж байв. Зөвхөн 1962 оны 3-р улиралд гадаадын 273 мэргэжилтнийг хүлээн авч орон байр олгох болон бусад үйлчилгээгээр хангажээ. 1962 онд 40 автомашины гараажийг уурын зуухны хамт бариулж ашиглалтанд оруулав.

1962 оны 3 дугаар сард гаргасан нэгэн судалгааны материалаас үзвэл Улаанбаатарт ЗХУ-аас 723, Болгараас 62, Чехословакаас 13, Хятад, Унгараас 3, Германаас 2, Солонгосоос 1 мэргэжилтэн ажиллаж байжээ.

Гадаадын мэргэжилтний үйлчилгээ, хангамжийн ажилд тохиолдож байсан гол бэрхшээл, дутагдал нь орон сууц хүрэлцээгүй, үйлчилгээний соёл, шуурхай байдал, ажилчды соёл, сахилга, хариуцлага хангалтгүй байсныг баримтанд тэмдэглэсэн байна. Энэ үеэс гадаадын мэргэжилтэнд бараг 100 шахам нэр төрлийн үйлчилгээ үзүүлж эхлэв. Энэ үед мэргэжилтний 24 байшин байжээ.

1963 онд тус газарт нэгдүгээр 40 мянгатын 48,49,50,53, хоёрдугаар 40 мянгатын 39,40,41, 50 мянгатын 1,2, мөн 20,5,7,13,15,17,12,14,76-р байшингууд харьяалагдаж, мэргэжилтнүүд амьдарч байжээ. Мөн онд 160 айлын орон сууц шинээр хүлээн авахаар төлөвлөж байв. <sup>2</sup> Орон сууцны тоо (фонд) нэмэгдэхийн хирээр үйлчилгээний ажлын хүрээ өсч ирэв. Сайд нарын Зөвлөлийн 1963 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 184 дүгээр тогтоолоор гадаадын мэргэжилтний орон сууцанд орос хэл дээр явуулах радио нэвтрүүлгийн шугам тавих, түүнд шаардагдах хөрөнгө гаргах, мэргэжилтний орон сууцны усан хангамжийг сайжруулах усны шугам хоолойг засахыг холбогдох яам, газруудад даалгаж гүйцэтгүүлжээ.

1963 онд тус газрын зохион байгуулалтанд дахиад л өөрчлөлт <sup>орж</sup> дрөв. Энэ удаа Сайд нарын Зөвлөлийн 1963 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн 318 дугаар тогтоолоор: "11. Улсын барилга, эдийн Засгийн Комиссын ерөнхий захиалагчийн газар татан буугдаж байгаатай холбогдуулан аж ахуйн тооцоогоор ажиллаж байгаа "Алтай зочид буудал, мэргэжилтний орон сууцны захиргаа, үйлчилгээний авто баазуудыг нэгтгэж аж ахуйн тооцоотой Мэргэжилтнийг үйлчлэх газрыг байгуулсугай" <sup>1</sup> гэж зааснаар тус газар хоёрдох удаагаа дахин байгуулагджээ. Тэгэхдээ уул газар Сайд нарын Зөвлөлийн Барилга, эдийн засгийн Комиссын харьяанаас гараагүй ажээ. Дахин байгуулагдсаны шалтгаан нь нэгд татан буугдсан ерөнхий захиалгагчийн газар мэргэжилтний үйлчилгээний асуудлыг хариуцаж байсан, хоёрт уг асуудлыг бие даасан байгууллага хариуцан гүйцэтгэхээс өөр аргагүй нь тодорхой болсонтой холбоотой байв.

Гадаадын мэргэжилтнийг үйлчлэх газрын даргаас 1961 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр гаргасан 141 дүгээр тушаалаар тус газрын үйл ажиллагаандаа баримтлах үндсэн зарчим, журам, ажлын арга барил зэргийг нэн тодорхой заажээ. Тэдгээр нь энэ байгууллагын үйл ажиллагаанд олон жил мөрдөгдөн хэвшсэнээрээ нэлээд онцлогтой юм. Иймд тэдгэр 10 гаруй зүйлээс зарим нэгийг энэ дашрамд товч дурьдъя <sup>бай:</sup>

Үүнд:

Орон сууцны захиргааны дарга гадаадын мэргэжилтэнд олгох байрыг засч, төхөөрөмжлөн бэлэн болгосны дараа өөрийн биеэр шалган үзсэний үндсэн дээр тэр байранд мэргэжилтнийг оруулдаг, шинээр ирж буй гадаадын мэргэжилтний байранд эвдэрч муудсан, элэгдэж хорогдсон зүйл тавих, нэгэнт тавьсан мебелиг өөрчлөн солих, зөөхийг хориглодог, мэргэжилтний гэр оронд нь санал, хүсэлтийн дэвтэртэй болгож, байрын төлөөлөгч тэдний гэр орноор сард 5-аас доошгүй удаа орж санал,

хүсэлтийг нь авч барагдуулан дэвтэрт нь тэмдэглэдэг, мэргэжилтний орон байрны орчныг байнга ариун цэвэр байлгаж, түүнд шаардагдах унаа, багаж хэрэгсэл, эд материалаар тогтмол хангадаг, гадаадын мэргэжилтэнтэй харилцах харилцааны соёлд хүмүүсээ сургаж, гарсан дутагдлыг тухай бүрд нь арилгадаг гэх мэт журмууд мөрдөгдөж хэвшсэн байжээ.<sup>1</sup>

1963 он гэхэд ГМУГ 130-аад ажиллагсадтай, 31684.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөтэй (тусад нь 5 жилээр гаргасан судалгаанд 33809.2 мянга гэсэн бий), 32904.8 мянган төгрөгийн дүрмийн сантай болоод байв. Авто бааз нь 50 орчим автомашинтай болжээ.<sup>3</sup> Тайлан балансаараа 23.8 мянган төгрөгийн ашигтай ажилласан гэж буй боловч тусад нь гаргасан судалгаагаар 95.2 мянган төгрөгийн алдагдалтай байснаар гаргажээ. Ямар ч байсан үндсэн хөрөнгө нь жил гаруйхны дотор 10 гаруй дахин нэмэгджээ. Энэ нь тус газрын түүхэнд дахин тохиолдоогүй зүйл болжээ. Үндсэн хөрөнгийн гэнэтийн энэ өсөлт нь юуны өмнө орон сууц олноор нэмэн авсан, авто бааз өргөжсөн, шинэ барилга, объект барьж эзэмших болсон зэрэгтэй холбоотой байв.

Тус газар улам өргөжсөөр байв. 1965 онд газрын авто баазад Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор ПАЗ 657-52 автобус 18-ыг олгов. 1965 оны эхэнд мэргэжилтний суудаг байруудыг хариуцах байрын төлөөлөгчдийг газрын даргын тушаалаар хуваарилжээ. Үүнээс үзвэл нэг төлөөлөгч 4-6 байшин хариуцдаг байжээ. Энэ үед газарт мэргэжилтний 31 байшин байжээ.

1960-аад оны дунд үеэс мэргэжилтний тоо бүртгэлийн нарийн хөтлөх болж, бүртгэл, карттай болжээ. Намын Төв Хороо, Сайд нарын Зөвлөлийн 1964 оны 140/252 дугаар тогтоолоор тус газрын авто гарааш нь яам, албан газруудад уригдан ирж Улаанбаатар хотод ажиллаж байгаа гадаадын мэргэжилтэн нарыг автобусаар үйлчлэх үүргийг хүлээв. Сайд нарын Зөвлөлийн 1965 оны 126 дугаар тогтоолоор газрын авто баазад Комби машин 15-ыг олгох, 1965 оны эхний хагаст багтаан нэмж 40 автомашин захиалж ирүүлэх, шаардагдах сэлбэг хэрэгслээр хангах, авто гараашийг биеэ даасан аж ахуйн тооцоотой авто бааз болгох зэрэг арга хэмжээ авчээ. Авто бааз жилдээ давхардсан тоогоор 3600-аад машинаар 480 албан газрын захиалгаар 10200-аад мэргэжилтэнд үйлчилж байжээ. Энэ үед зөвхөн зочид буудлаараа жилдээ давхардсан тоогоор 3400 гаруй хүн хүлээн авч үйлчлэх болжээ.

Тус газрын үйл ажиллагааны 1961-1965 оны эдийн засгийн зарим үндсэн үзүүлэлтийг холбогдох баримт, хэрэглэгдэхүүнээс түүвэрлэн авч хойно үзүүлэв: Үүнээс ГМУГ-ын ерөнхий төрх байдал харагдана гэж үзээд үүгээр товчлов.

ГМУГ-ын үйл ажиллагааны 1961-1965 оны эдийн засгийн зарим үндсэн үзүүлэлтүүд (мянган төгрөгөөр)

Үзүүлэлтүүд	1961	1962	1963	1964	1965	Таван жилийн дүн
1.Бүх орлого	3534.7	2848.4	3001.8	4292.3	4407.9	18085.1
2.Бүх зардал	2543.1	2797.1	3097.0	3519.3	3812.5	15769.0
3.Цэвэр ашиг	991.6	51.3	95.2	763.0	595.4	2316.1
4.Үндсэн хөрөнгө	3569.7	3476.2	33869.2	39441.4	40451.9	40451.9
5.Цалингийн сан	562.1	436.0	710.2	486.5	457.5	2549.1
6.Дүрмийн сан			32904.8	40555.0	41405.8	

7.Бүх ажиллагсад	130	129	129	113	117
8.Орлогын төгрөгт зардал	1	71.9	98.2	103.1	82.0
	ногдох (мөнгө)			82.0	86.4

1960-аад оны хоёрдох таван жилд ГМҮГ-ын үндсэн хөрөнгө, зардал төсөв, орон тоо нь нэмэдэн үйл ажиллагааны хүрээ улам өргөжиж иржээ. 1966 оны ажлын тайлангаас нь үзвэл тус газар захиргаа, авто бааз, зочид буудал, орон сууцны захиргаа, гуанз гэсэн нэгжүүдээс бүрдэж 240 гаруй хүн ажиллах болжээ. Авто бааз нь 61 машинтай, 74 ажиллчидтай болжээ. Энэ үед тус газарт 1653 айлын сууц бүхий 40-өөд байшин эзэмшигдэж, түүнд гадаадын мэргэжилтэн 2000 гаруй хүн гэр бүлийнхнийхээ хамт 5220 гаруй хүн амьдарч байжээ.

Барилгын засвар, үйлчилгээний ажил ихээхэн нэмэгдэж, төсөв зардал багагүй гарах болов. Гадаадын мэргэжилтэн олноор ирэх болсон нь орон байр хүрэлцэхгүйд хүрч, байр хүлээх, зочид буудалд олон сараар байрлөх, нэг байранд давхарлан суухад хүрдэг бэрхшээл ч гарч байв. Зөвхөн 1966 онд 570 мэргэжилтэн нэг байранд давхарлан сууж, 140 гаруй мэргэжилтэн байр хүлээж байна гэж тайландаа дурьджээ.

Тус газрын удирдлага, хамт олон гадаадын мэргэжилтнийг тохь тухтай байлгахын төлөө янз бүрийн арга хэллбэрийн ажил зохиодог байжээ. Мэргэжилтний санал хүсэлтийг зориуд сонсох, тэдний дундаас байрын зөвлөл г.м сайн дурын байгууллага байгуулж, тэднээр дамжуулан байрын дотоод дэг журмыг сайжруулах, эд хогшил, барилга байшинг ариг гамтай эдлүүлэхэд чиглэгдсэн ажил зохиодог байв. Байрын зөвлөлд тус оронд суугаа гадаадын элчин сайдын яамны зөвлөх хүртэл орж ажиллаж байсан үе ч байжээ.

1960-аад оны дунд үеэс ажилчдынхаа мэдлэг боловсрол, ажлын зохион байгуулалт, техник, технологийн үндэс, материаллаг баазыг бэхжүүлэхэд чиглэгдсэн "Техник-зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө", мөн байгууллагын жилийн зардал, ашиг, орлого, орон тоо, ажиллах хүчин, материалын элэгдэл, хорогдол, бэлтгэх зүйлийн тоо хэмжээ зэргийг тогтоож, төлөвлөхөд чиглэгдсэн "Үйлдвэр-санхүүгийн төлөвлөгөө"-тэй ажиллах болсон нь тухай үедээ шинэ, дэвшилттэй зүйл байлаа.

1967 оны 4 дүгээр сард МАХН-ын Төв Хороо, Сайд нарын Зөвлөлийн 69/106 дугаар тогтоолоор Улсын барилгын Зөвлөлийн (энэ үед ийм нэртэй болоод байсан) харьяа Гадаадын мэргэжилтнийг үйлчлэх газрыг Улаанбаатар хотын АДХГ захиргааны харьяанд эргүүлэн шилжүүлэв. Тус байгууллага хотын захиргаанд шилжин ирэх үедээ 244 ажиллагсадтай, зочид буудал, гуанз, авто бааз, орон сууцны хэлтэс (захиргаа)-тэй, 1966 оны тайлан балансаараа 40.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, орон сууцны 36 байшин, 61 автомашинтай, 1966 онд 754.4 мянган төгрөгийн ашигтай ажилласан байгууллага байжээ. (Тус газрын шилжүүлэн өгсөн тухай актыг хавсралтаас үзмүү.)

Мөн онд "Алтай" нэртэй, 360 ортой шинэ зочид буудал хүлээн авчээ. Зочид буудлын дотоод тоноглол, төхөөрөмжинд 670 мянган төгрөг зарцуулсан байна. Гуанз ч шинээр байгуулагдав. Гэвч зочид буудал 1968 онд л бүрэн ашиглагдаж эхэлжээ.

Зарим баримтанд дурьдсанаас үзвэл 1967 оны үед тус газраар гадаадын 8860 гаруй мэргэжилтэн үйлчлүүлж байсан ажээ. Үйлчилгээний хэмжээ, түүнтэй уялдан эд хогшил, материалын тоо хэмжээ нэмэгдсэнээс

15  
хэд хэдэн агуулах бариулсны нэгийг "төв" склад гэх болжээ. Тус газрын эзэмшилд байсан 60 хүний суудалтай мэргэжилтний гуанзыг 1968 онд хотын хүүхдийн сүүний үйлдвэрт шилжүүлэв. Шинэ гуанз нь хоёр ээлжээр ажиллах болжээ.

Тус газрын ажил, үйлчилгээнд шинэ, соргог зүйл нэлээд нэвтэрч эхлэв. Юуны өмнө үйлчилгээний нэр, төрлийг нэмэдүүлж, үйлчлэх ажлын дэг ёс, журам зарчмыг нарийг тогтоожээ. Жишээ нь: зочид буудалд байгаа мэргэжилтний ор дэрний цагаан хэрэглэлийг хэдийд хэрхэн сольж өгч байх, хоол ундыг хэрхэн бэлтгэж яаж зөөж өгч байх, радио, телевиз, зар сурталчилгаа, мэдээ мэдээлэл, хэвлэл номоор яаж хангаж байхыг хүртэл зааж тогтоосон журам гаргаж мөрдүүлжээ. Мэргэжилтэнд байр өгөхдөө гэрээ-ордодээр олгох журамд шилжив.

1960-аад оны эцсээс тус газар өөрийн орон сууцны их, бага бүх засвар, үйлчилгээг бүрэн хариуцан хийх болжээ. Засварт зарим жил 1 сая хүртэл төгрөг зарцуулах болжээ. 1960-аад оны сүүл үеэр тус газарт 39 байшин ашиглагдаж, түүнд 3000 орчим мэргэжилтэн гэр бүлийнхээ хамт амьдарч, үйлчлүүлж байгаа! *дгма.*

ГМУГ-ын 1966-1970 оны үйл ажиллагааны зарим үр дүнг хойно үзүүлэв. *Тал:*

Үзүүлэлтүүд	1966	1967	1968	1969	1970
1. Орлого	5125.3 (7406.8) <sup>1</sup>	5829.9	8486.3	9585.7	12107.6
2. Зардал	4925.3 (6752.4)	5360.5	7626.0	7976.8	8088.6
3. Ашиг	200.0 (754.4)	469.4	1060.3	1608.9	4019.0
4. Үндсэн фонд	40362.0	36337.6 (4040.0)	40794.9 (34032.7)	40646.8 (35334.6)	47167.2
5. Дүрмийн сан	-	-	-	35645	
6. Эргэлтийн хөрөнгө	2862.1	2983.0 (5600.0)	393.2 (4300.0)	-	2950.5
7. Цалингийн сан	610.4 <sup>2</sup>	612.5	931.7	970.2	1013.2
8. Нийт ажиллагсад	132 (234) <sup>3</sup>	142 (244)	210 (302)	219	221
9. Мэргэжилтний тоо	2000	-	-	3000	-
10. Мэргэжилтний байрын тоо. Үүнээс	40 (38) <sup>4</sup>	36 (39)	27 (43)	28 (47)	27 (46)
11. Шууд биш үйлчилгээтэй байшингийн тоо	-	-	19	19	19
12. Орлогын төгрөгт зардал нэг ногдох	96.1 (мөнгө)	91.9	87.7	83.2	66.8

Тайлбар:1.Орлогын хаалтанд байгаа то нь газрын тайлан балансанд байгаа тоо бөгөөд түүнд авто баазын орлогыг хамтатган оруулсан бололтой. Харин дээд тоо нь зөвхөн буудал, гуанз, орон сууцнаас оруулсан орлого ажээ.

2.Цалингийн санг зочид буудал, гуанз, орон сууцны захиргааны ажилчдын цалингаар боджээ.

3.Нийт ажиллагсад 234 байжээ. (Авто бааз ороод)

4.Зарим баримтанд 38 байшин байснаар бичжээ.

5.Хаалтанд байгаа тоонууд нь тайлан баланс, жилийн ажлын тайлан, бусад албан ёсны баримтанд байгаа тоо болно.

1970 онд газрын автобаазыг Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргаанд бүх эд хөрөнгө, орон тоо, авто машины хамт шилжүүлжээ. Ингэснээр газраас гадаадын мэргэжилтнийг авто хөсгөөр үйлчлэхгүй болжээ.

1971 онд гадаадын 280-аад мэргэжилтэн хүлээн авч байр олгон, 300-аадыг үдэж байжээ. 60 айлын орон сууцны байшин 1, өөр нэг байшин шилжүүлэн авсан, орон сууц, зочид буудлын дотоод тоног төхөөрөмж нилээдийг бэлтгэсэн зэргээс энэ онд зөвхөн үндсэн хөрөнгө нь 1523.6 мянган төгрөгөөр өсчээ. Барилга, байшин, эд хогшил өөр газар шилжүүлсэн зэргээс хөрөнгөний хэмжээ багасах тохиолдол ч зарим үед гардаг байжээ. Гэвч ерөнхий дүн хандлагаараа байнга өсч байлаа. Үүнийг 1971-1975 оны тус газрын үйл ажиллагааны эдийн засгийн дараахи зарим үзүүлэлтүүдээс харж болно. Үүнд:

(мянган төгрөгөө)

	1971	1972	1973	1974	1975
1.Орлого	12022.4	12218.3	11905.5	13743.6	13679.3
2.Зардал	383.0	10443.3	9400.3	9650.0	
3.Ашиг	2638.8	1775.0	3686.0	2620.0	4543.7
4.Үндсэн хөрөнгө	48043.2	47652.1	52245.3	57568.4	
5.Дүрмийн сан	40414.0	40845.0	44416.5	47569.5	
6.Нийт ажиллагсад	212	187	195	204	
7.Цалингийн сан (жилийн)	1145.4	1010.1	1128.7	1128.7	
8.Орлогын нэг төг- рөгт оногдох зар- дал (мөнгөөр)	78.1	85.4	74.5	78.0	71.2
9.Газрын харьяанд байсан орон сууц- ны тоо	2235	2055	2065	2065	

Тайлбар: ГМҮГ-ын 1975 оны тайлан баланс архивт үлдээгүй учир тус газрын мөн оны зардал, үндсэн хөрөнгө, дүрмийн сан, ажиллагсад, цалингийн сангийн тоо хэмжээг энд тусгаж чадаагүй болно. Дайварын чанартай зарим баримтаас үзвэл үндсэн хөрөнгө нь энэ үед 60 гаруй саяд хүрч, ажиллагсад нь 250 орчим болоод байжээ. 1972 он гэхэд газрын зочид буудлын гуанз 250 гаруй нэр төрлийн халуун хоол, хагас боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэн гуанз буфетээр 1300.0 мянган төгрөгийн борлуулалт хийж, зочид буудал гадаадын 2700 хүнийг хүлээн авч үйлчилж байсан нь үйлчилгээний хүрээ өргөн байсаныг гэрчлэнэ.

1973 оны үед Улаанбаатарт гадаадын 1200 мэргэжилтэн ажиллаж байв. Тэдгээрийн 989 нь байранд, 231 нь зочид буудалд байж, тус газраар үйлчлүүлж байжээ.Энэ үед жилд 2-4 байр (байшин) хүлээн авч мэргэжилтэнд олгож байсан байна.

17

Сайд нарын Зөвлөлийн 1973 оны 12-р сарын 14-ний 438 дугаар тогтоолоор ГМУГ-ыг Нийтийн аж ахуй, үйлчилгээний яамны шууд харьяа газар болгов. 1971 оноос Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргаа, хотын нийтийн аж ахуйг удирдах газрын давхар удирдлаганд байсан тус газар ийнхүү нэгэн яамны газар болов.

Газрын хамт олон өндөр идэвхи, чармайлт гарган ажиллаж улс, хотын хэмжээнд социалист уралдаанд хэдэнтээ тургүүн болон бусад байранд шалгарч байв.

1971 онд тус газрын Ж. Ширбазар, Ө.Сурмаажав, Д.Баянтөр, З.Янжав, Н.Гүрсэд, З.Иванов, О.Цэцэгээ, Д.Лхамжав, ДЦэвээн, Г.Лиза, С.Дашдэлэг нарын зэрэг 13 хүнийг Улаанбаатар хотын тэргүүний үйлчлэгч, хүндэт үнэмлэх, үнэ бүхий зүйлээр шагнасан нь олноороо шагнагдсан анхны тохиолдол байв.

1975 онд социалист уралдаанд хотын хэмжээнд 2-р байр эзлэн жуух бичиг, 3000 төгрөгөөр шагнагджээ. 1975 онд тус газрын 60 хүн төрийн дээд болон удирдах дээд байгууллагын, 183 хүн өөрийн байгууллагын шагналаар шагнагджээ. 1976,1977,1978,1979,1982 онуудад социалист уралдаанд хотод 1-р байр эзлэн, жуух бичиг 2000-3000 төгрөгөөр шагнагджээ.

1970-аад оны дунд үеийн тус газрын ажил үйлчилгээний цар хүрээг дараахи тоо баримт харуулна. Тухайлбал, 1973 онд 209 орон сууц засварлаж, 1974 онд улсын хөрөнгө оруулалтаар 823.0 мянга, өөрийн эргэлтийн хөрөнгөөр 585.9 мянган төгрөгийн эд хогшлыг гадаадын мэргэжилтэн нарт зориулан бэлтгэж, 200 гаруй байгуулагатай орон сууцны гэрээ хийж, 2400 гаруй байр ашиглуулж байв. 1974 онд гадаадын мэргэжилтэн, тэдний гэр бүлийн 3600 гаруй хүнд зориулж төрөл бүрийн шүүгээ 230, матмал болон зөөлөн сандал 1700, модон болон төмөр ор 1000, ширээ 1000, хөнжил 900, хөнжлийн даавуу 2800-г бэлтгэн хангажээ.

Тус газар энэ үед зарим орон сууц, эд хогшлыг түрээслүүлдэг (840 мянган төгрөгөөр) байжээ. Жишээ нь 100 айлын орон сууц бүхий нэгэн байрыг Хөдөлмөр, цалин хөлсний Улсын Хороо, Хүүхдийн сүүний газар, зурагчин, гутлын дэлгүүр зэрэг газарт түрээсээр ашиглуулж байв. Үүнээс гадна Сайд нарын Зөвлөлийн 1967 оны 254 дүгээр тогтоолоор Зөвлөлтийн байгууллагуудад эзэмшүүлэхээр өгсөн 841 айлын байр бүхий 13 байшинг мөн түрээсийн хэлбэрээр ашиглуулж, эхэндээ зөвлөлтийн талаас хөлсийг төлдөг байжээ. Эдгээр байшингуудыг тус газрын шууд бус эзэмшлийн байшингууд гэдэг байсан бөгөөд тэдгээр нь 12,15-р хороололд байжээ.

1970-аад оны дунд үеэр газрын үйл ажиллагаанд шинэлэг зүйл нэлээд нэвтрэх болов. Юуны өмнө санхүүгийн төлбөр тооцооны ажлыг цэгцлэн төлбөрийн нэхэмжлэх, инкассын тооцоо, түргэн төлбөрийн систем зэргийг нэвтрүүлсэн нь өр авлагыг арилгах нөхцлийг бүрдүүлэв. Ашигт ажиллагааны түвшин дээшилж, нэг төгрөгт ногдох зардал хямдарч иржээ.

Энэ үед тус газар төлөвлөгөө, санхүү, орон сууц, үйлчилгээний хоёр хэлтэс, материал хангамжийн тасаг, орон сууц (ОС-ны захиргаа ч гэж хэлдэг байв), зочид буудал, гуанз, барилгын хэсэг, боловсон хүчний аппарат гэсэн зохион байгуулалтын нэгж хэсгүүдтэй ажиллаж байв. 1975 оны сүүлээр газраас хөдөлмөрийн зохион байгуулалтаа өөрчлөх, орон тоо хэмнэх саналыг НААҮЯ-нд тавьсныг яам дэмжин тушаал гаргажээ.

1976 оны эхнээс дотоод зохион байгуулалтандаа өөрчлөлт оруулж эхлэв. Тэр нь хөдөлмөрийн бүтээмж, үйлчилгээний соёл, шуурхай байдлыг дээшлүүлэх, ажиллагсдын чөлөөт цагийг нэмэгдүүлэхэд юуны өмнө чиглэгджээ. Мөн техник-эдийн засгийн зөвлөл байгуулж ажиллуулах, хөдөлмөр-зохион байгуулалтыг боловсронгуй болгох, ШБОС, тэргүүн



туршлагыг дэмжих ажил байнга зохиох болов. Эдгээр нь байгууллага шинэ удирдлагатай болсонтой нэлээд хэмжээгээр холбогдох ажээ.

Байгууллагын хамт олны дотроос олон хүн хот, салбар, байгууллагын хөдөлмөрийн аврага, гавшгайч, тэргүүний үйлчлэгч, ажилтан, ажилчин гэсэн цол, шагнал хүртэж зарим нь байгууллагын хүндэт самбар, сонин хэвлэлд гарч, нийтлэгдэж байлаа.

Тус газрын 1976-1980 оны үеийн үйл ажиллагааг эдийн засгийн зарим үзүүлэлтээр харуулбал:

**Эдийн засгийн зарим үндсэн үзүүлэлт (мянган төгрөгөөр)**

1.Үндсэн хөрөнгө	62323.2	-	66057.7 (62642.4)	63848.7	-
2.Дүрмийн сан	50761	-	53404.4 (50237.5)	51550.0	-
3.Орлого	16172.5	18509.5	17639.1	20551.0	24901.9
4.Ашиг	5888.2	7722.4	6867.1	8956.4	13985.6
5.Ажиллагсад	223	210	217	215	312

Тайлбар: 1.Судалгааны зарим баримтанд 1978 оны үндсэн хөрөнгө, дүрмийн санг тайлан балансанд буйгаас нэлээд багаар бичжээ. Тэдгээрийг хаалтанд оруулж бичив.

2.Энэ үед байгууллага ямар зардал төсөвтэй байсан нь тодорхойгүй учир бичигдээгүй болно.

Янз бүрийн сургалт, семинар зохиож ажилтан, ажилчдынхаа мэдлэг боловсрол, мэргэжлийг дээшлүүлж байв. 1977 онд тус газарт ажиллаж байсан 210 хүний 70 нь эрэгтэй, 140 нь эмэгтэй, 15 нь дээд, 94 нь тусгай ба бүрэн, бүрэн бус дунд боловсролтой, 4 хүн боловсролгүй, 52 нь МАХН-ын гишүүн, 30 нь эвлэлийн 204 нь үйлдвэрчний гишүүн байсан ажээ.

1978 оны сүүл үеэр гаргасан мэдээгээр бол тус газрын үйлчилгээний гол хэсэг болох орон сууцны байшин 34 байсан бөгөөд түүнд гадаадын мэргэжилтэн 1335, зөвлөлтийн байгууллагын 463, олон улсын байгууллагын болон дипломат албаны 217, монголын 228 айл сууж байжээ. Бусад байгууллага хүмүүст 297 айлын сууц түрээслүүлж, мөн 193 айлын сууц түрээслэн авч хүн суулгаж байв. Газрын мэдэлд энэ үед 2300 орчим айлын орон сууц байсан аж.

1978 оны сүүлээс газрын дотоод зохион байгуулалтыг өөрчлөх судалгаа, тооцоо хийж эхэлжээ. Хийсэн судалгаа, тооцооны үндсэн дээр 1979 оны эхээр газрын зохион байгуулалтыг өөрчлөх тухай саналыг НААҮЯ-нд тавьжээ. Уул саналыг НААҮЯ хүлээн авч, сайдын 1979 оны 3 дугаар сарын 13-ны тушаалаар газрын зохион байгуулалтыг 1979 оны 4 дүгээр сарын 1-нээс 1980 оны 1-р сарын 1-нийг хүртэл туршилтын журмаар өөрчилжээ.

Энэ өөрчлөлтөөр мэргэжилтний орон сууц, зочид буудлын үйлчилгээг байршилыг нь харгалзан хоёр хэсэгтэй (1,2-р систем гэж бас нэрлэж байжээ), өөр бас нэгэн хэсэгтэйгээр хэсгийн системээр зохион байгуулжээ. Үүнтэй уялдуулан газрын даргын тушаалаар, орон тоо, цалин, дүрэм, заавар, ажлын хуваарь зэргийг шинэчлэн батласан байна. Орон тоо, цалин төдий л нэмэгдээгүй бололтой. Харин хэсэг, салбар бүрд ажиллах хүч, хөрөнгө материал хуваарилан өгч, урамшууллын санг бий болгосон байна. Хэсэг, салбар бүр ажлын үр дүн, ашигтай холбон урамшууллыг сар бүр тодорхойлон гаргаж газрын даргын тушаалаар

14  
51

олгодог, мөн бие дааж тайлан баланс гаргадаг журам тогтоожээ. Үйлчилгээний эдгээр хэсгүүд нь 1980 оноос орон сууц, зочид буудлын системүүд (1,2,3-р системүүд г.м) болж тус бүрдээ захиргаатай болжээ. Энэ системүүд 1980-аад оны сүүл хүртэл байжээ.

1979 онд 27 дугаар байр буюу "Хангай" зочид буудлыг тус газар хүлээн авчээ. Үүнтэй холбоотойгоор 1980 онд газрын ашиг орон тоо нэлээд нэмэгдэж 312 болж, цалингийн сан нь 1684.0 мянган төгрөгт хүрэв. 1980 онд газрын мэдлийн 50-иад байшинд гадаадын мэргэжилтнүүд суулгаж үйлчилж байжээ.

ГМҮГ 1980 оны эхний хагас жилд хотын хэмжээнд социалист уралдаанд 1-р байр эзлэн шагнагджээ. Энэ онд тус газрын хүндэт дэвтэр бий болж, түүнд ахмад ажилчин Гончигийн Цэсэндугамыг бичжээ. Мөн онд байгууллагын хөдөлмөрийн аврага цолоор С.Аюурзана, Б.Думхүү, Ч.Бямбажавыг шагнаж хүндэт дэвтэртээ бичжээ.

1980-аад оны сүүл хүртэл тус газар үйлчилгээнийхээ хүрээг улам өргөжүүлж, эдийн засгийн хувьд бэхжсээр байлаа. Энэ үеийн газрын гол үйл ажиллагааг харуулахуйц баримт бичгүүд бас л цөөн хадгалагджээ. Зарим баримтаас үзвэл 1980-аад оны хэний 5 жилд тус газар 340-350 орчим ажиллагсадтай байлаа. 1980 онд зохион байгуулагдсан бүтэц-зохион байгуулалт хэлбэрийн хувьд бараг хэвээр хадгалагдаж, харин зарим хэлтсүүд нэмэн байгуулжээ. Жил тутам орлогын төлөвлөгөөгөө дунджаар 2 сая 500 мянгаар давуулж байсан бөгөөд орлого, үйлчилгээ нь ойролцоогоор 31-33 сая төгрөгт хүрчээ. Үндсэн хөрөнгө нь 90 шахам сая төгрөг, дүрмийн сан нь 70 гаруй сая төгрөгт хүрэв. Үйл ажиллагаанаасаа 20 сая шахам төгрөгийн цэвэр ашиг олох болов. 1980-аад оны дунд үед тус газар орон сууцны 70-аад байшинтай, түүнд 5074 мэргэжилтэн, гэр бүлийн 15300 -аад хүн сууж үйлчлүүлж байжээ. Газар 920 ортой хоёр томоохон зочид буудлаар үйлчилж байлаа. Зардал, төсөв хэмнэж, ашиг, орлогыг нэмэгдүүлэх талаар чармайн ажиллаж байв.

Үүний дүнд орлогын нэг төгрөгт ногдох зардал жил бүр дунджаар 2.5 мөнгөөр хямдарч, орлогын төлөвлөгөөг жил бүр дунджаар 2 сая төгрөгөөр давуулж байсан ажээ. Эдийн засгийн эдгээр өсөлт, үр дүн нь үйлчлүүлэгчдийн тоо, үйлчилгээний өртөг жил тутам өсч, материаллаг бааз бэхжин, байгууллагын аж ахуйг хөтлөх, үйлчлэх ажлын арга барил, зохион байгуулалт сайжирч, улсаас ч ихээхэн анхаарч байсан зэрэгтэй холбоотой байв.

1980-аад оны сүүлээр тус газар орон тоо, төсөв хөрөнгөөр нилээд нүсэрдүү болж иржээ. 1987 онд үндсэн хөрөнгө нь 100 шахам сая, дүрмийн сан нь 80-аад сая төгрөгт хүрчээ. Орон сууц, ахуй үйлчилгээний олон хэсэгтэй, тэдгээрийг удирддаг орон сууц, зочид буудлын захиргаатай, мөн дээр нь дөрвөн томоохон хэлтэстэй байв. 1987 онд ОСЗБ-ын хоёр ч захиргааг татан буулгасан байна. Хэсгүүдийг мэргэжлийн хэлтсүүд шууд удирдах болов. Ингэснээр удирдлагын давхардал багасаж, орон тоо хэмнэгдэн, ажил шуурхай явагдах болжээ.

1988 оны үеэс гадаадын мэргэжилтнүүд олноор буцах болов. Ялангуяа 1989 онд Сайд нарын Зөвлөл "Гадаадын мэргэжилтний захиалга, ашиглалт, ахуйн үйлчилгээг сайжруулах зарим арга хэмжээний тухай" тогтоол гаргасны дараа гадаадын мэргэжилтнийг урих, ашиглах, тэднээс суралцах, урьж ирүүлсний зардал төсвийг гаргахад шинэ шаардлага, журам тогтож, уул тогтоолд дурьдсанчлан "...мэргэжилтэн захиалах, тэднээс суралцах ажилд хариуцлагагүй хандаж нэг мэргэжлээр олон дахин мэргэжилтэн урих..." явдал цөөрсөн байна. Нөгөө талаар тэр үеийн ЗХУ болон бусад социалист гэгдэж байсан оржуудтай тогтоосон эдийн засаг,

соёл шинжлэх ухааны харилцаанд өөрчлөлт орж, түүний холбоотойгоор тэдгээр оронтой хамтран шинээр үйлдвэр, аж ахуйн газар барьж байгуулах зэрэг ажил цөөрч иржээ.

Мөн гадаадын мэргэжилтнийг үндэсний мэргэжилтнүүд орон ажиллах боломж, чадавхи ч зарим талаар бий болж байлаа. Эдгээр болон өөр бусад учир шалтгааны улмаас шинээр гадаадаас мэргэжилтэн урих, ирснийг удаан хугацаагаар ажиллуулах явдал ямар нэгэн хэмжээгээр багасаж байжээ.

1980-аад оны эцэс, 1990-ээд оны эхэн үед тэр үеийн ЗХУ болон европын социалист гэгдэж байсан улс орон мөн Монголд өрнөсөн улс төрийн үйл явдлууд нь Монголд гадаадын мэргэжилтэн урьдын адил ажиллах нөхцлийг багасгасан нь түүхэн үнэн билээ. Энэ бүхэн нь гадаадын мэргэжилтний үйлчилгээ, хангамжийг эрхлэн хариуцаж байсан тус газрын үйл ажиллагаанд юуны өмнө нөлөөлсөн ажээ.

1989 онд гадаадын мэргэжилтэн олноор буцсанаас сууцууд суларч ашиглалтгүй болсныг Хотын гүйцэтгэх захиргааны мэдэлд шилжүүлжээ. Харин шилжүүлж буй орон сууцыг ГМҮГ-ын төсөв зардлаар бүрэн засварласны дараа шилжүүлдэг байв. Тухайлбал 1990 онд шилжүүлсэн орон сууцнуудыг 1.5 сая төгрөгөөр засарлаж байжээ. 1990 оны эх хүртэл тус газарт 45 байшингийн 5000 гаруй орон сууц ашиглагдаж байгууллага 20-иод сая төгрөгийн ашигтай ажилласаар байв. Нэгэн баримтанд дурьдсанаас үзвэл 1990-1992 онд 36 байшингийн 4000 орчим айлын орон сууцыг хотын гүйцэтгэх захиргаанд шилжүүлжээ.

"Алтай" зочид буудлыг Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны шийдвэрээр 1990 оны 7 дугаар сард МАХН-ын Төв Хорооны Хэрэг эрхлэх газарт, мөн "Хангай" зочид буудлыг түрээсээр өөр эзэнд эд хогшил, тоног тавилга, орон тооны нь хамт тус тус шилжүүлжээ. Нэг жилийн өмнө байсан орон тоогоо нэг илүү дэхин цөөрүүлж, 135-138 хүн болгожээ. Харин цалин хэрэглэл, урамшил шагнал урьдын адил олгогдож байсан байна.

Хотын гүйцэтгэх захиргааны дээр өгүүлсэн тогтоолоор Гадаадын мэргэжилтнийг үйлчлэх газрыг Гадаадын мэргэжилтнийг үйлчлэх Контор болгон хотын орон сууц, нийтийн аж ахуйг удирдах газрын харьяанд шилжүүлжээ. Энэ үед тус газар (контор) нь захиргаа, ОСАУ-ний 1,2-р хэсэг, хангамжийн тасаг (хэсэг), барилга засварын хэсэг гэсэн зохион байгуулалтанд ороод байлаа.

1986 оноос тус газрын даргаар ажиллаж байсан Р.Нямцэрэн 1990 оны 7 дугаар сарын 16-наас "Алтай" зочид буудалд МАХН-ын Төв Хорооны хүсэлтээр ажиллах болж, Б.Бямбасүх тус конторын дарга болсон байна.

1991 оны эхний хагас жилийн байдлаар 1.9 сая төгрөгийн алдагдалтай ажиллах болжээ. Оны эхэнд байсан 8.8 сая төгрөгийн чөлөөт үлдэгдэл оны сүүлийн хагаст 1.1 сая болж буурчээ. Үүнийг тэр үеийн байдлыг мэдэх хүмүүс энэ байгууллага дампуурахад хүрчээ гэж үзэж байжээ.

Урьд нь тогтсон удирдлага, зохион байгуулалтын бүтэц эвдэрч, удирдлага, бүртгэл тооцоо, хяналт шалгалт, сахилга дэг журам суларч, хийсэн үйлчилгээнийхээ хөлсийг авч чадахгүй болсныг баримтад дурьджээ.

Урьд нь ондоо 30 гаруй сая төгрөгийн орлого оруулдаг байсан бол 1991 оны эцсийн дүнгээр 6059.0 мянган төгрөгийн орлого оруулжээ. Энэ нь орлого 5 илүү дахин буурчээ гэсэн үг юм. Үүний гол шалтгаан нь мэргэжилтнүүд олноор буцаж, тэдний сууж байсан орон сууц ашиглалтгүй болж, орлого буурсанд оршиж байв. Дээрхи бүх байдал нь тус газар цаашид оршин тогтнох эсэхэд эргэлзэхэд хүрсэн байв.

1991 оны дундуур тус конторын шинэ удирдлага байдлыг судлаад байгууллагыг дампуурлаас гаргах арга замыг төлөвлөж хэрэгжүүлжээ. Үүнд юуны өмнө удирдлага, зохион байгуулалтаа улс төр, эдийн засгийн шинэ нөхцөл байдалд тохируулан өөрчлөв. Жилийн ажлын товч тайлангаас үзвэл 1994 онд Контор орон сууц, ашиглалт үйлчилгээний 7 хэсэг, зочид буудал, захиргаа гэсэн шинэ зохион байгуулалтанд оржээ.

Үйлчилгээний гол цөм болсон ОСАУ-ний хэсгүүдийг бэхжүүлэх, тэдгээрийг аж ахуйн дотоод тооцоонд оруулж, бие даалгах зорилт дэвшүүлэн ажиллав. 1991 онд хотод 15 байшин шилжүүлж, 15 байшинтай үлджээ. Байгууллагын дотоод дүрэм, хамтын гэрээг шинэ байдалд тохируулан шинэчлэн баталж мөрджээ. Дампуурахаас аврах эдийн засгийн үр ашигтай арга механизмыг сүвэгчлэн эхний шатанд орон сууцны илүү хэсгийг шилжүүлж, эд хөрөнгөний ашиглалт, хадгалалт, бүрэн бүтэн байдалд тавих хяналт, бүртгэл тооцооны ажлыг эмхлэн цэгцлэв. Үйлчилгээний бааз, соёл, чанар, хариуцлагыг дээшлүүлж, тэр хэмжээгээр үнэ тарифийг нь шинэчлэн өөрчлөв. Ашиг, орлогод тавих хяналтын механизмыг бүрдүүлж эхлэв. Энэ бүхний үр дүн гарч 1991 оны эцэс гэхэд алдагдлаа хаасан байна. "Зул" нэртэй зочид буудлыг 1991 оноос тохижуулан ашиглахаар бэлтгэжээ. Хэдийгээр орлого, ашиг буурч, байгууллага жижгэрч байсан боловч 1991 он гэхэд 448 айлын орон сууцны сантехник, гэрэл, цахилгаан, барилгын засварыг бүрэн хийж хотын захиргаанд хүлээлгэн өгч байжээ. Цаашид тус газрын өмнө байгууллагыг зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжүүлэх, цоо шинэ арга барилаар ажиллах зорилт тулгарчээ. Ялангуяа өөрийн эдийн засгийн гол суурь болох орон сууцны ашиглалтыг сайжруулах, гадаадын иргэдэд үзүүлэх үйлчилгээг шинэ нөхцөл байдалд тохируулах явуулах шаардлага хурцаар тавигджээ. Эдгээр зорилт, шаардлагыг хуучин бүтэц, зохион байгуулалт, арга барилаар хэрэгжүүлэх боломжгүй байлаа.

Энэ бүх байдлыг дүгнэж, судалгаа, тооцоо хийсний үндсэн дээр Конторыг Компани болгон өөрчлөн байгуулах саналыг хотын холбогдох газруудад тавьжээ.

✓ Конторын саналыг хотын удирдлага дэмжиж, Улаанбаатар хотын АХГ захиргааны 1992 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 200 дугаар тогтоолоор "Гадаадын харьяат иргэдэд үйлчлэх "Гэгээ" компани" болгон байгуулагдсан бөгөөд ингэснээр харьяалал нь дахин өөрчлөгдөж ОСНААУГ-ын харьяанаас гарч, хотын гүйцэтгэх захиргааны шууд харьяа болжээ. Энэхүү тогтоолоор Компаний дүрмийн санг нь 28.7 сая төгрөгөөр тогтоож, түр дүрмийг нь баталсан байна. Мөн үйлчилгээний чанар, орон сууцны сангийн хуваарьлалт, ашиглалт, үнэ тарифийн зэрэг асуудлын чиглэлээр Компанитай гарээ байгуулан ажиллахыг Хотын гүйцэтгэх захиргааны Хэрэг эрхлэх газарт үүрэг болгожээ. Ийнхүү "Гэгээ" нэртэй нэгэн компани Монголын нийслэлд үүсэн бий болов.

1991 оны сүүл, 1992 оны эхний хагас жилд олсон зарим ахиц, мөн компани болон эрс өөрчлөлт хийсэн нь цаашдын зорилтыг хэрэгжүүлэхэд суурь болж өгөв. Юуны өмнө Компани болсноор хотын ОСНААУГ-ын харьяаллаас гарч хотын гүйцэтгэх захиргаанд шууд харьяалагдан асуудал шийдэхэд нэгэн шат дамжлага хасагдав. Урьд нь жилдээ 5-10 сая төгрөгийг ОСНААУГ-ын нийгмийн хөгжлийн сан, бусад туслах сангийн хэлбэрээр дээд байгууллагад төвлөрүүлэн авч байснаас өөрийн зорилтыг хэрэгжүүлэхэд ашиглахад бэрхшээл учруулж байсныг арилгав. 1992 онд 4 байшинг улсад шилжүүлж, 9 байшинтай үлджээ.

1993 он гэхэд барилга байшин засах, байрыг хашаажуулах, харуул хамгаалалттай болгох, эд хөрөнгө худалдаж авах зэрэгт 20 гаруй сая төгрөг зарцуулах болж, эдийн засгийн хувьд сэргэж эхэлжээ.

Компаний эдийн засаг, техникийн бодлогын явц, үр ашгийг тооцоолох зорилгоор удирдлагын автоматжуулсан систем нэвтрүүлж, 20 сая шахам төгрөгийн үнэ бүхий өнгөт телевизор, хөргөгч, бусад тавилга төхөөрөмж зэргийг хөрөнгө оруулалтаар бэлтгэн, дүрмийн сангаа нэмэгдүүлсэн нь үйлчилгээний чанар, хүрээг дахин өргөтгөхөд нэгэн алхам болжээ.

Ийнхүү дампуурах аюулд ойртож байсан нэгэн байгууллага сэхэх тийшээ мөлхөж, 1994.1995 онуудад мөлхөх биш, алхаж эхлэв. 1994 оны үед байгууллагын удирдлагаас дэвшүүлж байсан зорилт, санал дүгнэлтийг ажиглахад үйлчилгээний агуулга, хэлбэр, зохион байгуулалтыг эрс өөрчлөх, материаллаг баазаа шинэчлэх, сэлбэн тордох, үйлчилгээг ойртуулах, зах зээлийн үйлчилгээнд суралцах зэрэгт гол анхаарлаа хандуулж эхэлжээ. Энэ үеэс улс, хотоос нэг ч төгрөг авахгүй үйл ажиллагаагаа явуулах зорилт дэвшүүлсэн байна. Энэ үед компанид ердөө 6 байшин, 348 байр сууцтай, түүнд дэлхийг 30 шахам орны иргэд үйлчлүүлж байжээ.

Гадаадад хүмүүсээ явуулж, сургах, дотооддоо гадаад хэл сургах арга хэмжээ авч эхлэв. Энэ нь олон улс орны иргэдтэйд чөлөөтэй харьцахад чухал шаарлагатай зүйл байсан нь тодорхой. Байгууллагын үйл ажиллагаанд орчин үеийн техник, тоног төхөөрөмж, нэвтрүүлэх, ялангуяа холбооны найдвартай сүлжээг бий болгох арга хэмжээ авчээ.

Үйлчилгээг "худалдаж" өндөр ашиг, орлоготой ажиллах гэдэг зорилт дэвшүүлж ажилласан нь энэ үеийн нэгэн шинэлэг зүйл болжээ. Тэр нь уг утгаараа олон төрлийн, ойр дөт, боловсон шуурхай үйлчилгээ, байр орон сууцны болон зочид буудлын тохь тухтай байдал, гадаад дотоод орчин ахуйн тохижилт гэх мэт олон зүйлийг орчин үеийн шаардлагад хүргэж үйлчилгээг явуулна гэсэн үг байжээ.

1995 он бол Компаниас дэвшүүлсэн дээрхи зорилтыг хэрэгжүүлэхэд шийвэрлэх он байжээ. Энэ онд менежментийг өөрчлөн зохион байгуулж бие даан хөгжих нөхцлийг бүрдүүлэх, эдийн засгийн хүч нөөцөө бэхжүүлэх, үйлчилгээний удирдлагыг нэг гарт төвлөрүүлж, нэр төрөл, фонд ашиглалтын чанарын үзүүлэлтийг дээшлүүлэхэд гол үйл ажиллагаагаа чиглүүлжээ.

Компаний хамт олон энэхүү дэвшүүлсэн зорилтоо хэрхэн биелүүлж буйг компаний 1993, 1995 оны эдийн засгийн зарим үзүүлэлтийг хооронд нь харьцуулан гаргасан дараахи жишээнээс харж болно. (Сая төгрөгөөр)

	1993	1995
1.Бүх орлого	82.2	174.0
2.Ашиг	15.9	89.0
3.Ашигт ажилла- гааны түвшин	019	039

1995 онд орлогын 1 төгрөгийн ногдох зардал 1993 оныхоос 020 мөнгөөр буурсан байв. Компани улсад 21.5 сая төгрөгийн татвар өгөх болов. Зөвхөн зочид буудлаараа 1995 онд валют, төгрөгийн нийт дүнгээрээ ойролцоогоор 57 сая шахам төгрөгийн орлого олсон нь 1994 оныхоос 2.4 дахин нэмэгдсэн байна.

Одоо компани жилдээ 13.7 сая шахам төгрөгийн засвар, тохижилтын ажил гүйцэтгэх болсон. Компани компьютерийн мэдээллийн "Интернет" сүлжээнд холбогдож, олон хүнээ пейжерийн холбоотой, зочид буудал,

компания факсын үйлчилгээтэй болгосон нь орчин үеийн харилцаа холбоотой болж, улмаар үйлчилгээний хүрээг өргөн, шуурхай, соёлч үйлчлэх техник-эдийн засгийн үндэс бүрдэхэд чухал алхам болжээ.

Одоо тус компани нь хэсгийн зохион байгуулалттай. Үүнд: Захиргаа (үүнд ламбард орно), 40 ортой "Гэгээ" зочид буудал, үйлчилгээний хэсэг (гуанз), засварын хэсэг, ашиглалт үйлчилгээний 5 хэсэг, нийт 9 хэсэг нэгжтэй. Байгууллагын өсч өөдлөх нь түүнийг бүрдүүлж, ажил үйлсийг нь явуулдаг хүний мэдлэг боловсролоос шууд шалтгаална гэдгийг компаний удирдлага онцгой анхаарч, ажилтнууддаа гадаад хэл сургах, компьютерийн дадлага туршлага эзэмшүүлэх, хууль эрх зүйн мэдлэг олгох хичээл заах, гадаад орны үйлчилгээний байгууллагын туршлагаас суралцуулах ажлыг хийдэг байна. Компани ажиллагсадынхаа нийгмийн асуудал, ахмад хүмүүсийнхээ талаар багагүй анхаарч, ихээхэн төсөв зардал гаргаж байна.

**ТОВЧ ДҮГНЭЛТ**

40 жилийн тэртээ бий болсон гуравхан хүний орон тоотой жижигхэн хэсэг (групп)-ээс өнөөгийн "Гэгээ" компанийг хүртэл энэ нэгэн байгууллага өсч хөгжих, уруудаж буурах, ахин сэргэж сэргэхийн аль алиныг үзэж туулсан ажээ.

Монгол орон гадаад улс төр, эдийн засгийн харилцаа эрчимтэй өрнөж эхэлсэн 1950-аад оны эцэс, 1960-аад оны эхэнд үүсэн бий болж, тэрхүү өрнөлт дэвшилттэй түүхэн уялдаа холбоотойгоор өсч хөгжиж байсан тус байгууллага 1960-аад оны эхнээс 1970-аад оны дунд үеийг хүртэл материаллаг бааз, хүн хүч, ажил үйлчилгээнийхээ үндсэн суурийг бүрдүүлж чадсан юм.

Энэ хугацаанд тус байгууллага дээд, дунд шатны янз бүрийн байгууллагын харьяанд орж, гарч бүтэц, зохион байгуулалтанд нь их бага өөрчлөлт шинэчлэлт орж, зарим үед бүр татан буугдаж байсан боловч үндсэн үүрэг, үйл ажиллагаа нь үргэлжилж, эдийн засгийн талаар өргөжин бэхжиж, үйл ажиллагаа нь үндсэн хэв шинжээ бүрэн олж чадсан үе байв. Энэхүү эхний 15-16 жилийг тус байгууллагын үүсч, улмаар өргөжин хөгжсөн нэгэн үе гэж үзэж болох юм.

1973 онд тус байгууллагыг шинэхэн байгуулагдаад байсан Нийтийн аж ахуй үйлчилгээний яам, Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны давхар харьяалалд (давхар удирдлагад) оруулав. Ингэснээр нэг талаар төрийн захиргааны салбар хариуцсан мэргэжлийн байгууллагын харьяалалд орж, мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын шууд удирдлага хүлээх болов. Нөгөө талаар хотын байгууллагын хувьд хотын гүйцэтгэх захиргааны удирдлага, туслалцаа авах, ялангуяа орон сууц хуваарьлуулалтад хамтран ажиллах болсон юм.

Энэ үеэс гадаадын мэргэжилтнийг үйлчлэх газар бүтэц, зохион байгуулалт, ажлын арга барил, сахилга дэг журам, байгууллагын санхүү, эдийн засгийн асуудалд ихээхэн анхаарах болж, тэдгээрийг сайжруулах, өөрчилж шинэчлэх талаар багагүй зүйл хийж эхэлсэн юм. Ингэснээр нэгэн үе нэлээд зогсонги, задгай байдалд орсон тус газар бас нэгэн шинэ байдлаар үйл ажиллагаагаа явуулсан бөгөөд тэр нь 1975 оны үеэс 1980-аад оны дунд үеийг хүртэл үргэлжилсэн гэж болно. Чухамхүү энэ үед тус газар улс, хот, салбартаа ажил үйлсээрээ олонтоо шалгарч, нам, төр, олон нийтийн төв болон орон нутаг, салбарын байгууллагын өндөр нэр хүндтэй шагналыг бараг жил дараалан авчээ. Байгууллагын удирдлага хамт олныг

зөв зохион байгуулж удирдаж чадсан, улсаас онцгой анхаарч байсан, хамт олны идэвхи сэргэж хийж бүтээхийг төлөө үнэнхүү сэтгэлээр хөдөлмөрлөсөн, цалин хөлс, шагнал урамшилын тогтолцоог хөдөлмөрийн эцсийн үр дүн, чанартай холбон зөв хэргэлэсэн зэрэг нь энэ үеийн амжилтын гол хүчин зүйл , хөшүүрэг нь болсон юм.

1980-аад оны сүүл үеэс монгол оронд , мөн түүнтэй улс төр, эдийн засаг, соёл шинжлэх ухааны өргөн харилцаатай байсан олон улс орнуудад болж байсан нийгэм улс төр, эдийн засгийн үйл явдлуудын нөлөөгөөр Монголд гадаадын мэргэжилтэн ирэх нь эрс цөөрч, ирсэн нь буцах учир шалтгаан ч гарснаар гадаадын мэргэжилтнүүд цөөрч, үүнтэй уялдан ГМҮГ-ын үйл ажиллагаа, хөрөнгө санхүү буурах хандлаганд орж, улмаар 1990, 1991 оны үед байгууллага өөрөө оршин тогтнох, эсэх нь тодорхойгүй болтлоо доошилжээ.

Үүний учир шалтгааныг бас дан ганц гадаад, дотоод улс төр , эдийн засгийн тухайн үеийн таагүй байдалтай холбон тайлбарлах нь өрөөсгөл учир дутагдалтай. Үүнд удирдах дээд байгууллага нь татан буугдсан, өөрийн дарга удирдлагаа богино хугацаанд хэдэнтээ сольсон, хамгийн гол нь болж буй үйл явдлуудыг зөв үнэлж өөрчлөлт, шинэчлэлтийг цаг алдалгүй хийж чадаагүй, удирдлагын ажлын арга барил, мэдлэг чадвар мөхөсдөж, ажил сулран салан задгай байдал үүссэн зэрэг нь ихээхэн нөлөөлжээ.

1991 оны эцэс, 1992 оноос байгууллага дахин сэхэж сэргэх замд оржээ. Тэгэхдээ үүрэг зорилтоо зах зээлийн эдийн засгийн харилцааны нөхцөл байдалд зохицуулан цоо шинэ зарчмаар тодорхойлсон бөгөөд бодит үйл ажиллагаа нь ч түүндээ захирагдан явагджээ. Байгууллагын шинэ удирдлага хамт олон тухай үеийн байдал, орчин нөхцөл, цаг үеийг зөв үнэлж, зөв ажиллаж чадсанаар өнөөдөр "Гэгээ" компани өсч өөдлөх замдаа нэгэнт орж, ирээдүйгээ өөдрөгөөр харж, "гэрэл, гэгээ" бүхий замаар алсын оргил өөд авирч эхэлсэн байна.

Зорьсон хэрэг нь сэтгэлчлэн бүтэж, сайн үйлс нь дэлгэрэх болтугай.

**Зохиогч**

**Гадаадын мэргэжилтнийг үйлчлэх байгууллагын дарга нарын овог нэр, албан тушаал, ажилласан хугацааны тодорхойлолт**

- 1.Зундуй. (овог тодорхойгүй)
  - Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх техникийн тусламж, мэргэжилтний асуудлыг эрхэлсэн засгийн газрын төлөөлөгч.
  - 1957 оны 7-р сарын 9-нөөс
  - 1960 оны 7-р сарын 2
- 2.Рагчаасүрэн. Овог тодорхойгүй
  - Мэргэжилтэн нарын ахуй хангамжийг эрхэлсэн группийн ахлагч (дарга)
  - 1957 оны 8-р сарын 15-наас
  - 1958 оны 9-р сарын 1
- 3.Ононхүү. Овог нь олдоогүй
  - Гадаадын мэргэжилтнийг үйлчлэх товчооны дарга
  - 1958 оны 9-р сараас
  - 1959 оны дунд үе

- 25
4. Дашзэвэг. Овог нь олдоогүй  
Гадаадын мэргэжилтнийг үйлчлэх товчооны дарга  
1959 оны дунд үеэс  
1960 оны 7-р сар
  5. Балдан. Овог нь олдоогүй  
Гадаадын мэргэжилтнийг үйлчлэх газрын дарга  
1960 оны 7-р сараас  
1961 оны 5-р сарын 25
  6. Зул  
Гадаадын мэргэжилтнийг үйлчлэх газрын дарга  
1961 оны 5-р сарын 25-наас  
1963 оны 12-р сарын 31
  7. Базарын Цэдэн-Иш  
Гадаадын мэргэжилтнийг үйлчлэх газрын дарга  
Ажилласан хугацаа нь тодорхойгүй
  8. Балдан. Овог нь олдоогүй  
Гадаадын мэргэжилтнийг үйлчлэх газрын дарга  
1963 оны 12-р сарын 31  
1964 оны 9-р сарын 18
  9. Сангирагчаагийн Ядамсүрэн  
Гадаадын мэргэжилтнийг үйлчлэх газрын дарга  
1964 оны 9-р сарын 18  
1972 оны 5-р сар
  10. Дашбалын Дулмаа  
Гадаадын мэргэжилтнийг үйлчлэх газрын үүрэг  
гүйцэтгэгч  
1972 оны 5-р сар  
1972 оны 7-р сар
  11. Сангийн Дашдорж  
Гадаадын мэргэжилтнийг үйлчлэх газрын даргын үүрэг  
гүйцэтгэгч  
1972 оны 7-р сарын 26  
1975 оны 2-р сарын 1
  12. Доржийн Цэрэндулам  
Гадаадын мэргэжилтнийг үйлчлэх газрын дарга  
1975 оны 2-р сарын 1  
1985 оны 2-р сарын 1
  13. Р. Нямцэрэн  
Гадаадын мэргэжилтнийг үйлчлэх газрын дарга  
1985 оны 2-р сарын 1  
1990 оны 7-р сарын 17
  14. Б. Бямбасүх  
Гадаадын мэргэжилтнийг үйлчлэх конторын дарга  
1990 оны 7-р сарын 17  
1991 оны 7-р сар
  15. Ишгээгийн Бямбарагчаа  
Гадаадын мэргэжилтнийг үйлчлэх конторын дарга  
1991 оны 7-р сарас  
Одоо хүртэл

ТОДОРХОЙЛОЛТ ГАРГАСАН

Ч.МИЖЭЭХҮҮ